



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,  
ШИЙДВЭР, НИЙТЛЭЛ—ХУУЛИЙН  
ТАЙЛБАР)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№

1991 оны 6 сар

№ 6 (25)

## ГАРЧИГ

### 1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |   |     |
|---|-----|
| 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай                | 425 |
| 2. Захирааны хариуцагчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 431 |
| 3. Парлютын зохицуулалтын тухай                             | 432 |
| 4. Хууль хүчингүй болсонд тооцох тухай                      | 441 |
| 5. Төрийн бэлгэ тэмдгийн тухай                              | 442 |

### 2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

- |  |     |
|--|-----|
| 6. Гэрээнд гарми үсэг зурах бүрэн эрх олгох тухай № 29 | 454 |
| 7. Дүрэн батлах тухай № 30                             | 455 |
| 8. Алсхан хэсэг байгуулах тухай № 31                   | 458 |
| 9. Аймаг, сүм байгуулах тухай № 32                     | 459 |
| 10. Сүм байгуулах тухай № 33                           | 461 |
| 11. Сүм байгуулах тухай № 34                           | 464 |
| 12. Зарим хотын хороос татан буузагах тухай № 35       | 468 |
| 13. Зарим хот, хороодмыг сумдад нэгтгэх тухай № 36     | 469 |

### 3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |   |     |
|---|-----|
| 14. Шашны агуудал эрхэлсэн зөвлөлийг шашнычлан байгуулах тухай № 31 | 473 |
| 15. Шашны агуудал эрхэлсэн түшмэлийн орон тоо бий болгох тухай № 52 | 477 |
| 16. Зарим хүнийг медалиар шагнах тухай № 53                         | 478 |

#### 4. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

17. Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийн орон тоо, бүтцийг тогтоох, дүрэм, төсвийс олгох санхүүжилтийн хэмжээ, сарын цалингийн санг батлах тухай № 52 479
18. Орон сууцны салбарыг зах зээлийн харицаанд шилжүүлэх бэлтгэлийг хангахтай холбогдсон зарим эрх хэмжээний тухай № 55 484

#### 5. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

19. Эрүүгийн хуулийн 32-р зүйлийг нэг мөн ойлгоц эвч хэрэглэх тухай № 30 494

#### 6. НИЙТЛЭЛ, ТАЦЛААР ЗӨВЛӨМЖ

20. Монгол Улсын Валютын зохицуулалтын тухай хуулийн агууага, өнцлөг 497
21. Монгол Улсын Төрийн бэлэг тэмдгийн тухай хуулийн талаар 502

МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ

1994 оны 5 дугаар  
сарын 10 ны өдөр

Улаанбаатар  
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН  
АЛБАНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэсэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны (иашинд «шийдвэр гүйцэтгэлийн алба» гэх) зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, ажлын эрх, үүргийг тодорхойлох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэлийн албаны тогтолцоо

1. Шийдвэр гүйцэтгэлийн алба нь Шүүхийн Тамгын газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хянан байцаах хэлтэс, аймаг, нийслэлийн болон дагнасан шүүхийн тамгын хэлтсийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тасаас бүрдэнэ.

2. Ажлын шаардлагыг хэргэлзэн сумын буюу сум дундын дүүргийн шүүхэд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрээр шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хэсэг байгуулан ажиллуулж болно.

3 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэлийн албаны удирдлага

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хянан байцаах хэлтэс Шүүхийн тамгын газрын, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тасаг, хэсэг тухайн аймаг, нийслэлийн болон дагнасан шүүхийн тамгын хэлтсийн даргын өдөр тутмын удирдлагад ажиллана.

2. Шүүхийн тамгын газар нь шийдвэр гүйцэтгэлийн албыг удирдахдаа дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1) шийдвэр гүйцэтгэлийн албыг зохион байгуулалтын болон арга зүйн нэгдмэл удирдлагаар хангах,

2) шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тасаг, хэсгийн ажлыг зохицуулан зохион байгуулах, хянан шалгах;

3) Улсын ерөнхий гүйцэтгэгчийн шийдвэрийг хянаж өөрчлөх буюу хүчингүй болгох;

4) шийдвэр гүйцэтгэлийн албаны боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах;

5) шийдвэр гүйцэтгэлийн албаны санхүүгийн болон бусад хангалтыг эрхлэх;

6) хуульд заасан бусад асуудал.

**4 дүгээр зүйл.** Шийдвэр гүйцэтгэлийн албаны үйл ажиллагааны эрх зүйн үндэс, зарчим

1. Шийдвэр гүйцэтгэлийн алба нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, бусад хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг удирдлага болгоно.

2. Шийдвэр гүйцэтгэлийн алба нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, төлбөр, тэтгэлэг авагч, төлөгчийн хууль ёсны эрх шигийг хүндэтгэх зарчмыг баримтална.

**5 дугаар зүйл.** Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтан

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хянан байцаах хэлтэст Улсын ерөнхий гүйцэтгэгч, шадар гүйцэтгэгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тасаг, хэсэгт ахлах гүйцэтгэгч, гүйцэтгэгч ажиллана.

2. Улсын ерөнхий гүйцэтгэгч, шадар гүйцэтгэгч, ахлах гүйцэтгэгч нь улсын байцаагчийн эрх эдэлж дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1) шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбогдсон асуудлаар аж ахуйн нэгж, байгууллагын ажлыг шалгах;

2) шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, хуурамч гэрээ хийж эд хөрөнгөө бусдад шилжүүлсэн, нуусан, битүүмжилсэн эд хөрөнгийг санаатайгаар үрэгдүүлсэн, төлбөр төлөгчийн налин орлогоос суутгал хийгээгүй, дугуу суутгасан, суутгасан мөнгийг хуульд заасан хугацаанд олоогүй буюу шилжүүлээгүй, төлбөр, тэтгэлэг төлөгчийг ажлаас халагдсаныг мэдэгдээгүй иргэн, албан тушаалтанд хуульд заасан журмын дагуу захаргааны шийтгэл ногдуулах.

**6 дугаар зүйл.** Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтан хэрэг дэн

1. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтан нь шүүхийн тэргүүн гүйцэтгэгч, шүүхийн дэд гүйцэтгэгч, шүүхийн гүйц

гаар гүйцэтгэгч, шүүхийн дөтгөөр гүйцэтгэгчийн зэрэг дэвтэй байна.

2. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны зэрэг дэнийг Шүүхийн ерөнхий зөвлөл олгоно.

3. Зэрэг дэв олгохдоо албан тушаалын ангилал, ажилласан дугацаа, мэргэшлийн түвшинг харгалзана.

4. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны зэрэг дэвийн нэмэгдэл олгох журмыг Сангийн яамтай зөвшилцөн Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

7 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтныг томилгох, чөлөөлөх.

Улсын Ерөнхий гүйцэтгэгч, шадар гүйцэтгэгч, ахлах гүйцэтгэгчийг Шүүхийн тамгын газрын дарга, гүйцэтгэгчийг шүүхийн тамгын хэлтсийн дарга тухайн шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн томилж, чөлөөлнө.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

**Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны бүрэн эрх, үйл ажиллагааны баталгаа**

8 дугаар зүйл. Гүйцэтгэгчийн нийтлэг бүрэн эрх

1. Гүйцэтгэгч нь дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) шийдвэрийг сайн дураар гүйцэтгэхийг шаардах, шийдвэр, шүүхийн мэдэгдлийг биелүүлсэн эсэхийг аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа, санхүүд шалгах;

2) харуулагч төлбөрийг сайн дураар төлөхөөс зайлсхийсэн, орлого, эд хөрөнгөө нүүсэн тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орж үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураах, нүүгдмал хөрөнгө илрүүлэх, хураагдсан эд хөрөнгийг худалдан борлуулах зэрэг ажиллагаа явуулах;

3) албан үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуудаж хүч хэрэглэх буюу хэдэглэхээр давдаж эсэргүүцэл үзүүлсэн этгээлд зохих журмын дагуу бороохой, нулимс асгаруулагч хэрэглэх;

4) хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг эригтүүлэх, эрүүгийн хэрэг, захиргааны зөрчлийн шинэж буй баримт илэрвэл долбогдох байгууллагад мэдэгдэх;

5) хуульд заасан бусад бүрэн эрх.

2. Гүйцэтгэх хуудас болон түүнтэй адилтгах баримт бичиггүйгээр төлбөр, тэтгэлэг гаргуулахыг хориглоно.

9 дүгээр зүйл. Улсын ерөнхий гүйцэтгэгчийн бүрэн эрх

Улсын ерөнхий гүйцэтгэгч нь шадар гүйцэтгэгч, гүйцэтгэгчийн нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) гүйцэтгэлийн албыг мэргэжлийн удирдлагаар хангах;

2) шадар гүйцэтгэгч, ахлах гүйцэтгэгчийг томилж, чөлөөлж тухай синалыг Шүүхийн тамгын газарт оруулах;

3) шадар гүйцэтгэгчийн шийдвэрийг хянаж өөрчлөх буюу хүчингүй болгох;

4) хуульд заасан бусад бүрэн эрх.

10 дугаар зүйл. Шадар гүйцэтгэгчийн бүрэн эрх

Шадар гүйцэтгэгч нь гүйцэтгэгчийн нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тасаг, хэсгийн ажлалт баримтын шалгалт хийх;

2) ахлах гүйцэтгэгч, гүйцэтгэгчийн шийдвэрийг хянаж өөрчлөх буюу хүчингүй болгох;

3) хуульд заасан бусад бүрэн эрх.

11 дүгээр зүйл. Ахлах гүйцэтгэгчийн бүрэн эрх

Ахлах гүйцэтгэгч нь гүйцэтгэгчийн нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тасаг, хэсгийн ажлыг шуурхай удирдлагаар хангах;

2) гүйцэтгэгчийн шийдвэрийг хянаж өөрчлөх буюу хүчингүй болгох;

3) гүйцэтгэгчийг томилж, чөлөөлж талаар синал гаргах;

4) гүйцэтгэгчийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд баримтын шалгалт хийх;

5) гүйцэтгэх баримт бичгийн нэгдсэн бүртгэл, данс мөрдөх, мэдээ, тайлан тэнцлийг нэгтгэн хуульд заасан журмын дагуу гаргах;

6) хуульд заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны үйл ажиллагааны эрх зүйн болон нийгмийн баталгаа

1. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны хууль ёсны шаардлагыг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэд заввал биелүүлнэ. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй иргэн, албан тушаалтанд хуульд заасан харуулагаа хүлээлгэнэ.

2. Шүүхийн тухай хуулийн 58 дугаар дүвлийн 2 дахь хэсэгт зааснаар гүйцэтгэгч ялгах тэмдэг, албаны дүрэмт хувцас, бороохой, нулимс асгаруулагч хэрэглэнэ.

3. Ялгах тэмдэг, албаны дүрэмт хувцасны загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, бороохой, нулимс асгаруулагч хэрэглэх журмыг Улсын Ерөнхий прокурортой зөвшилцсөний үндсэн дээр Шүүхийн Ерөнхий зөвлөл тогтооно.

4. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтан, албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан эрүүл мэндэд нь хохирол учруулсны улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон тохиолдолд олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг олгоно.

5. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны амь нэсыг албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан хөнөөсөн тохиолдолд түүний ар гэрт хохирогчийн 3 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

6. Энэ дүвлийн 4, 5-т заасан үндсэн цалингийн зөрүү, буцалтгүй тусламжийг төсвөөс олгож, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

7. Ахлах гүйцэтгэгч, гүйцэтгэгч нарт ажлын үр дүнгийн шагналыг удирдал тутам олгох бөгөөд шагналын хэмжээ нь нэг сарын үндсэн цалингийн хэмжээгээс хэтэрч болохгүй.

Ажлын үр дүнгийн шагнал олгох журмыг Сангийн нэгтэй ашиглалт Шүүхийн тамгын газар тогтооно.

8. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтнаас үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн албан тушаалтан бүх талын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

9. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтан албан үүргээ гүйцэтгэж байх үедээ нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зардлыг Шүүхийн тамгын газраас тогтоосон журмын дагуу нөхөн олгоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажиллагаанд тавих хяналт

13 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажиллагаанд тавих хяналт

Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажиллагаанд бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, тамгын газар, хэлтсийн дарга, Улсын Ерөнхий гүйцэтгэгч, шадар гүйцэтгэгч, ахлагч гүйцэтгэгч тус тусын эрхлэх ажлын хүрээнд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн дагуу хяналт тавина.

14 дүгээр зүйл. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтанд хүлээлгэх хариуцлага

Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтан өөрийн хууль бус ажиллагааны болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөний голлох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

15 дугаар зүйл. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах

1. Шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны шийдвэр, үйл ажиллагааны тухай гомдлыг шийдвэрийг мэдсэнээс хойш 10 хоногийн дотор дээд шатны албан тушаалтанд гаргана. Дээд шатны албан тушаалтан гомдлыг 21 хоногийн дотор шалгаж амьдавчирлана.

2. Дээд шатны албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргаж болно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл

16 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хууль 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ

1994 оны 5 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны харнуцлагын тухай хуульд дөр дурдсан агуулгатай дараахь зүйл, заалт нэмсүгэй:

10 дугаар зүйлийн 1 дэх заалтад «30<sup>3</sup>» гэсний дараа «30<sup>4</sup>», 5 дахь заалтад «26» гэсний дараа «30<sup>4</sup> дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг».

30<sup>4</sup> дүгээр зүйл:

«30<sup>4</sup> дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх

1. Шийдвэр гүйцэтгэлийн албанд дуудагдсан этгээд хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, хүрэлцэн ирэхэд нь саад учруулсан бол 200—5000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Албан үүргээ гүйцэтгэхэд нь санаатайгаар саад учруулсан, эсэргүүцсэн, албан үүрэгтэй нь холбогдуулан доромжилсон, гүтгэсэн заналхийлсэн, хүч хэрэглэсэн нь эрүүгийн харнуцлага хүлээлгэхээргүй бол 5000—25000 төгрөгөөр торгох, эсхүл 7—14 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна.

3. Шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, хуурамч гэрээ хийж эд хөрөнгөө бусдад шилжүүлсэн, нуусан битүүмжилсэн эд хөрөнгийг санаатайгаар үрэгдүүлсэн бол 5000—10000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

4. Төлбөр төлөгчийн цалин орлогоос суутгал хийгээгүй, дутуу суутгасан, суутгасан мөнгийг хуульд заасан хугацаанд олтоогүй буюу шилжүүлээгүй, төлбөр, тэтгэлэг төлөгчийг ажлаас халагдсаныг мэдэгдээгүй бол 1000—15000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 5 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь валютын зохицуулалтын талаарх төрийн зохих байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд валютын гүйлгээ хийх, валютын гүйлгээнд хяналт тавих, Монгол Улсын үндэсний валютыг үнэгүйдлээс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Валютын зохицуулалтын тухай хууль тогтоомж

1. Валютын зохицуулалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөр журам тогтоосон бэл олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

1. «Валют» гэж Монгол Улсын үндэсний валют, гадаад валют, улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж буй тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлсийг хэлнэ.

2. «Үндэсний валют» гэж эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөг, түүгээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг хэлнэ.

3. «Гадаад валют» гэж эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий нэг буюу хэд хэдэн гадаад улсын мөнгөн тэмдэгт, тэд-

гээрээр нээрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг хэлнэ. Гадаад валютыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөндөр чөлөөтэй хөрвөдөг ба чөлөөтэй хөривдөггүй гэж ангилна.

4. «Мөнгөжсөн алт» гэж олон улсын жишигт хүргэн цэвэршүүлж, олон улсын санхүүгийн аль нэг төвд хадгалуулж байгаа, гадаад валютаар борлуулахад бэлэн болсон алтыг хэлнэ.

5. «Валютын үнэт зүйлс» гэж мөнгөжсөн алттай адилгах үнэт металл, эрдэнийн чулууг хэлнэ.

6. «Цэвэршүүлсэн алт» гэж алтны агуулгыг нь нэмэгдүүлж цэвэршүүлсэн боловч гадаад валютаар шууд борлуулах их-өөд хангагдаагүй алтыг хэлнэ.

7. Валютын харилцаанд оролцогч байнга оршин суугч (иашид «байнга оршин суугч» гэх) гэж:

1) Монгол Улсад байнга оршин суугаа, мөн байнга оршин суудаг боловч 183 хоногоос дээшгүй хугацаагаар гадаадад зорчиж байгаа хувь хүн;

2) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, Монгол Улсад оршин байрладаг хуулийн этгээд, түүний гадаадад байгаа салбар, төлөөлөгчийн газар;

3) гадаад улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрыг тус тус хэлнэ.

8. Валютын харилцаанд оролцогч түр оршин суугч (иашид «түр оршин суугч» гэх) гэж:

1) Монгол Улсын гадна байнга оршин суудаг, мөн Монгол Улсад 183 хүртэл хоногийн хугацаагаар байгаа хувь хүн;

2) Гадаад Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, Монгол Улсад оршин байрладаггүй хуулийн этгээд, түүний Монгол Улс дахь салбар, төлөөлөгчийн газар;

3) Монгол Улсад байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар болон олон улсын байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газрыг тус тус хэлнэ.

4 дүгээр зүйл. Монгол Улсын валютын гадаад нөөц

1. Монгол Улсын валютын гадаад нөөц нь төрийн эрх бүхий байгууллагын болон арилжааны банкны эзэмшилд байгаа;

1) гадаад орны банк, санхүүгийн байгууллагад хадгалж байгаа мөнгөжсөн алт;

2) чөлөөтэй хөрвөдөг гадаад валют;

3) гадаадад чөлөөтэй төлөгдөх болон гадаадын үнэт цаасны зах дээр борлогдох бүх төрлийн үнэт цаас;

4) энэ хэсгийн 1, 2-т зааснаас бусад олон улсын хэмжээнд валютын нөөцөд тооногддог үнэт зүйлийн активээс бүрдэнэ.

2. Төрийн өмчид байгаа энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зүйл нь төрийн эрх бүхий байгууллагын эзэмшилд байгаа валютын гадаад нөөцөд хамаарна.

3. Монгол Улсын болон төрийн эрх бүхий байгууллагын эзэмшилд байгаа валютын гадаад цэвэр нөөцийг валютын гадаад нөөц тус бүрийн нийт дүнгээс гадаадаас авсан холбогдох богино хугацаат зээл, хадгаламжийг хасаж тодорхойлно.

**5 дугаар зүйл.** Монгол Улсын валютын зах, ханш

1. Эрх бүхий банк, бирж, брокерийн компаниас эрэлт, нийлүүлэлтийн үндсэн дээр хийж байгаа валютын худалдаа арилжааны үйл ажиллагааг Монгол Улсын валютын зах гэнэ.

2. Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг валютын зах дээр арилжааны банкуудын худалдсан, худалдаж авсан гадаад валютын ханшид үндэслэн тус улсын гадаад худалдаанд зонхилон хэрэглэж байгаа тогтвортой ханш бүхий чөлөөтэй хөрвөдөг аль нэг гадаад валютын тухайн үеийн ханштай жишин тогтоож нийтэд зарлана.

3. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг урьд өдрийн ханшаас 5 буюу түүнээс дээш хувийн хэлбэлзэлтэйгээр өсгөх буюу бууруулах тохиолдолд Монгол Улсын Ерөнхий сайдтай зөвшилцөнө. Зөвшилцөөнд хүрээгүй нь Монгол банкны Ерөнхийлөгч шийдвэр гаргахад саад болохгүй.

4. Арилжааны банк нь валютын захын эрэлт, хэрэгцээнд үндэслэн валют худалдах, худалдан авах өөрийн ханшийг тогтооно.

5. Төсөв, гзалийн тооцоонд Монголбанкнаас тогтоосон ханшийг хэрэглэнэ.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

### Валютын зохицуулалтын талаар төрийн байгууллагуудын эдлэх бүрэн эрх

**6 дугаар зүйл.** Улсын Их Хурлын бүрэн эрх

Улсын Их Хурал валютын зохицуулалтын талаар даргах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) валютын талаарх төрийн бодлогыг тодорхойлох;

2) гадаадаас авах Засгийн газрын зээл, Монгол Улсын гадаад төлбөрийн тэнцлийн төслийг хянан шийдвэрлэх;

3) төрийн өмчид байвал зохих валютын гадаад цэвэр нөөцийн доод хэмжээг тогтоох;

4) Улсын нөөцөд байгаа цэвэршүүлсэн алтыг валютын гүйлгээнд оруулах тухай шийдвэр гаргах;

5) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

**7 дугаар зүйл.** Засгийн газрын бүрэн эрх

Засгийн газар валютын зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) гадаад валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийг сайжруулах арга хэмжээ авах;

2) Монгол Улсын гадаад төлбөрийн тэнцэл зохиож, биелэлтэд нь хяналт тавих;

3) гадаадаас авах Засгийн газрын зээл, түүний төлбөртэй холбогдсон санал боловсруулах, хэрэгжүүлэх;

4) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

**8 дугаар зүйл.** Монголбанкны бүрэн эрх

Монголбанк нь валютын зохицуулалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) улсын хэмжээнд валютын гүйлгээг зохицуулж, хэрэгжүүлэх;

2) Улсын валютын гадаад нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

3) Монгол Улсын болон гадаадын валютын зах дээр эрх хэмжээнийхээ дотор валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцоо эрхлэх;

4) төрийн өмчид байвал зохих валютын гадаад цэвэр нөөцийн доод хэмжээ тогтоох тухай санал боловсруулж шийдвэрлүүлэх, түүнийг хадгалах, оновчтой, үр ашигтай байршуулах;

5) Засгийн газрын валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцоог гүйцэтгэх;

6) байнга оршин суугчид гадаад төлбөр, тооцоо хийх болон гадаад бэлэн валютаар гүйлгээ эрхлэх зөвшөөрөл олгох, биелэлтэд нь хяналт тавих, зөвшөөрлөө нуцлах;

7) валютын гүйлгээний тайланг, мэдээ гаргах журмыг тогтоох;

8) валютын гүйлгээний нэгдсэн тайлан, мэдээг Улсын Их Хуралд удирал бүр оруулж байх;

9) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## ГЭРЭВДЭГЭЭР БҮЛЭГ

### Валютын гүйлгээ хийх

#### 9 дүгээр зүйл. Валютын гүйлгээ

1. Валют худалдах, худалдан авах, хадгалах, зээлдэх, нилжүүлэх, байршуулах, барьцаалзах, улсын хилээр оруулах, гаргахтай холбоотой үйл ажиллагааг валютын гүйлгээ гэнэ.

2. Банк нь гадаад валютын гүйлгээг түүнтэй тэнцэх хэмжээний үндэсний валютын гүйлгээтэй нэгэн зэрэг гүйцэтгэнэ.

3. Монгол Улсын үндэсний валют, чөлөөтэй хөрвөдөггүй гадаад валютыг Монгол Улсын хилээр оруулах, гаргах, валютын гүйлгээнд ашиглах журмыг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдтай хамтран батална.

#### 10 дугаар зүйл. Монголбанкны эрхлэх валютын гүйлгээ

1. Монголбанк нь Монгол Улсын валютын гадаад нөөцийг нэмэгдүүлэх, зохицуулах зорилгоор тус улсын болон гадаад орны банк, бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс валют, цэвэршүүлсэн алт худалдан авч болно.

2. Монголбанк нь төгрөгийн ханшийг тогтвортой байлгах зорилгоор өөрийн эзэмшилд байгад валютын гадаад нөөцөө гадаад валютыг худалдана.

#### 11 дүгээр зүйл. Арилжааны банкны эрхлэх валютын гүйлгээ, эрх, үүрэг

1. Арилжааны банк нь Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн хүрээнд валютын гүйлгээний дараахь үйл ажиллагааг эрхэлж болно:

1) гадаад валютын бэлэн бус төлбөр, тооцооны үйл ажиллагаа эрхлэх;

2) гадаад валютыг бэлнээр худалдах, худалдан авах;

3) байнга болон түр оршин суугчдын нэр дээр гадаад валютын данс нээж, гүйлгээ хийх;

4) гадаад валютаар зээл олгох, баталгаа гаргах зэрэг актнэ, нэвсгэний бүх төрлийн ажил, гүйлгээ эрхлэх.

2. Валютын гүйлгээ эрхэлж байгаа арилжааны банк дараахь үүрэгтэй байна:

1) валютын гүйлгээний талаарх тайлан, мэдээг тогтоосон журмын дагуу гаргах, мэдээлж байх;

2) төгрөгийн ханшид нөлөө үзүүлэхүйц гүйлгээг Монголбанкны зөвшөөрлөөр гүйцэтгэх;

3) харилцагчийнхдаа гадаад валютын дансны нууцыг хадгалж, найдвартай байдлыг хангах;

4) гадаад валютын гүйлгээг харилцагчийн анхны шаардлагаар хийх, хөрөнгийнх нь үлдэгдэлд хүү төлөх.

3. Арилжааны банк нь гадаад валютын ажил, үйлчилгээндээ ногдуулах шимтгэлийг өөрөө тогтооно.

**12 дугаар зүйл.** Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гадаад валютын гүйлгээ

1. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2, 3 мөн зүйлийн 8 дахь хэсэгт заасан байнга буюу түр оршин суугчид нь гадаад валютыг худалдах, худалдан авах болон зээлдэх, шилжүүдэх ажыгзлагааг зөвхөн Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэнэ.

2. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2, 3-г заасан байнга оршин суугч нь орлогоо гадаад валютаар бэлтгээр буюу бэлэн бус төлбөрийн хэрэгслээр авсан бол Монголбанкнаас эрх олгосон арилжааны банкинд уг орлогыг авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор худалдах буюу хадгалуулна.

3. Монголбанкны зөвшөөрлөөр гадаад бэлтгээр валютаар ажил, үйлчилгээ эрхэлж буй энэ хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2-г заасан байнга оршин суугч нь өдөр тутмын гүйлгээ хийхэд шаардагдхаас бусад гадаад валютыг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу зохих хугацаанд банкинд худалдах буюу хадгалуулна.

4. Монгол Улсын иргэд болон энэ хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2, 3-г заасан байнга оршин суугч нь гадаадад зөрөнтө байршуулах, зээл, тусламж олгохдоо Сангийн яаманд бүртгүүлнэ.

5. Байнга болон түр оршин суугч нь арилжааны банкнаас гадаад валют худалдан авах, зээлдэх, банкинд худалдах, зээлдүүдэх гэрээ, зээлийн баталгааг бичгээр үйлдэнэ.

**13 дугаар зүйл.** Валютыг Монгол Улсын хилээр оруулах, гаргах

1. Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн валютыг гаалийн байгууллагад бичгээр нэвдүүлсэн тоо, хэмжээгээр тус улсын хилээр оруулж болно.

2. Монгол Улсад байнга болон түр оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүн валютыг дор дурдсан журмаар тус улсын хилээр гаргаж болно:

1) гадаад төлбөр, тооцооны эрх бүхий арилжааны банкнаас худалдан авсан, чөлөөтэй хөрвөдөг гадаад валютыг тухайн банкны нотолгоо бичгээр;

2) гадаадаас оруулж ирсэн бол түүнийгээ нотлох галийн мэдүүлгээр;

3) өв залгамжлан авсан болон бусдаас бэлэглэсэн бол түүнийгээ тус улсын нотариатын байгууллагын нотолгоо бичгээр;

4) Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар.

3. Монгол Улсын иргэн чөлөөтэй хөрвөдөг гадаад валютыг хууднаар хязгаар тогтоогоогүй бол гаальд мэдүүлсэн тоо, хэмжээгээр тус улсын хилээр гадаадад гаргаж болно.

**14 дүгээр зүйл.** Гадаад валютын зээл, төлбөр, тооцоо

1. Гадаад орон болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас Засгийн газрын шугамаар авсан гадаад зээл, тусламжийн нэгдсэн бүртгэлийг Сангийн яам хөтөлнө.

2. Засгийн газрын шугамаар авах гадаад зээлийн баталгааг Засгийн газрын зөвшөөрснөөр Сангийн сайд гаргана. Сангийн сайдын баталгаагүй авсан зээлийн төлбөрийг Засгийн газар хариуцахгүй.

3. Гадаад орон болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, тусламжийн хөрөнгийг Засгийн газар нь Монголбанк болон түүнээс гадаад төлбөр, тооцооны эрх олгосон арилжааны банк, бусад аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр худалдах буюу зээлдүүлж болно.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан зээлийн гэрээнд хүү, төлөх хугацаа, зориулалт, хүлээх хариуцлага зэргийг талууд харилцан тохиролцож тусгана.

5. Засгийн газрын гадаадаас авсан зээлийг ашиглагч банк, бусад аж ахуйн нэгж, байгууллага нь уг зээлийг эргүүлж төлөх хөрөнгийн эх үүсвэрийг тухай бүр бүрдүүлж төсөвт төлнө.

6. Төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгж Сангийн яамны зөвшөөрлөөр гадаадаас валютын зээл авна. Монгол Улсын бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрсдийн гадаадаас авсан валютын зээлийг Монголбанкинд бүртгүүлнэ.

7. Төсвийн санхүүжилтээр хийх гадаад төлбөрийг зөвхөн тухайн санхүүгийн байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

8. Сангийн яам нь Засгийн газрын валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцоог банкаар дамжуулан хийнэ.



9. Байнга болон түр оршин суугч нь Монголбанкнаас гадаад төлбөр, тооцооны эрх олгосон арилжааны банк болон тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын банкны салбарт гадаад валютын дластай байж болно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Валютын гүйлгээнд тавих хяналт

**15 дугаар зүйл.** Хяналт тавих байгууллага

Монгол Улс дахь аж ахуйн нэгж, байгууллагын валютын гүйлгээнд Засгийн газар, Монголбанк өөрсдийн бүрэн эрхийн дагуу хяналт тавина.

**16 дугаар зүйл.** Валютын хяналтын улсын байцаагч

1. Валютын хяналтыг Улсын ерөнхий байцаагч, Улсын ахлах байцаагч, улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

2. Валютын хяналтын Улсын ерөнхий байцаагч нь Монголбанкны ерөнхийлөгч, Улсын ахлах байцаагч нь валютын асуудлыг эрхэлсэн Монголбанкны дэд ерөнхийлөгч байна.

3. Валютын хяналтын улсын байцаагчийг Улсын ерөнхий байцаагч томилно.

**17 дугаар зүйл.** Валютын хяналтын байгууллагын үүрэг, улсын байцаагчийн бүрэн эрх

1. Монголбанк нь дараахь үндсэн үүрэгтэй байна:

1) валютын зохицуулалтын тухай хууль тогтоомжийн биеэлэлтийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад өмчийн төрөл, хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах;

2) валютын гүйлгээтэй холбоотой баримт, сэлтийг шалгах;

3) валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцооны ажиллагааны талварх бүртгэл, тайлан, мэдээний үнэн зөвийг шалгах;

4) эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан эрхийн актыг валютын гүйлгээнд мөрдөж байгааг шалгах.

2. Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээ, хуульд зассан үндэслэлээр өөрийн эзэмшилд байгаа валютын ашиглалт, зарцуулалтад хяналт тавих бөгөөд нийхүү хяналтаа Сангийн ямаар дамжуулан хэрэгжүүлнэ.

3. Улсын байцаагч нь валютын хяналтын үүргээ биедүүлэхдээ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) валютын гүйлгээ, гадаад төлбөр, тооцоонд холбогдох баримт сэлтийг үзэх, холбогдох албан тушаалтан, иргэнийг мэдээ, тодорхойлолт, тайлбар, шаардлагатай баримтын хуулбарыг гаргуулан авах;

2) валютын гүйлгээ, төлбөр, тооцоог хянах, шалгалтын дүнгээр акт тогтоож, гүйцэтгэлийг хангах, Улсын байцаагчийн акт нь валютын хяналтын Улсын ерөнхий буюу Улсын ахлах байцаагчийн баталснаар хүчин төгөлдөр болно. Тавьсан актад холбогдох албан тушаалтан, иргэнийг гарын үсэг зуруулна. Тэдгээрээс уул актыг хүлээн зөвшөөрөлгүй бол тайлбар гаргуулна;

3) илэрсэн зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг өгөх, шаардлага тавих;

4) тавьсан шаардлагыг биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хууль болон бусад хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэх;

5) хуулийн заалтыг зөрчсөн бол гадаад төлбөр, тооцоо хийх, валютын гүйлгээ эрхлэх зөвшөөрлийг нуцлах талаар валютын хяналтын Улсын ерөнхий байцаагчид санал тавих;

6) валютын зохицуулалтын тухай хууль тогтоомж зөрчсөн нь гэмт хэргийн шинжтэй байвал холбогдох баримт, сэлтийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад шилжүүлэх.

4. Валютын хяналтын улсын байцаагч нь валютын үйл ажиллагаанд тавих хяналтын явцад олж мэдсэн иргэд, байгууллага, банк, бусад аж ахуйн нэгжийн валютын хөрөнгө, худаадааны нууцыг хадгалах үүрэгтэй.

5. Валютын хяналтын байгууллагын албан тушаалтан нь үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд түүнд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

6. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн валютын гүйлгээний талаарх маргааныг шүүхээр шийдвэрлэнэ.

#### **18 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

1. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 1, мөн зүйлийн 8 дахь хэсгийн 1-д заасан хууль хүн болон албан тушаалтны дараах үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэргийн шинжгүй бол тэдгээрт дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1) энэ хуулийн 12 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн бол 5000—25000 төгрөгөөр торгох;

2) энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх заалт, 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 6

дахь хэсгийн заалтыг зөрчсөн бол 20000—25000 төгрөгөөр торгох;

3) энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2, 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн, мөн Монгол-банкны зөвшөөрөлгүйгээр буюу олгогдсон зөвшөөрлийн хүрээндээс гадуур энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаа явуулсан бол хууль буслар олсон орлого буюу эд зүйлийг хурааж 15000—25000 төгрөгөөр торгох.

2. Валютын зохицуулалтын тухай хууль тогтоомж зөрчсөнөөс бусдад учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлнэ.

**19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

Энэ хуулийг 1994 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын  
дэргэ

**Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 5 дугаар  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХУЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл, 1994 оны 3 дугаар сарын 18-ны өдөр батласан Валютын зохицуулалтын тухай Монгол Улсын хуульд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан уг хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын  
дэргэ

**Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 5 дугаар  
сарны 20 ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАН

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Ерөнхий зүйл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Төрийн сүлд, туг, далбаа, тамгыг үйлдэх, дүрслэх, дээдэв хэрэглэх журам болон Төрийн дууллыг хуульчлан баталгахад оршино.

2 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдэг

1. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрх байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал (цаашид «Төрийн бэлгэ тэмдэг» гэх) мөн.

2. Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.

3 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль тогтоомж

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### ХОЕРДУГААР БҮЛЭГ

Монгол Улсын Төрийн сүлд, түүнийг үйлдэх,  
дүрслэх, байрлуулах

4 дүгээр зүйл. Төрийн сүлд

Үндсэн хуулийн арван хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Төрийн сүлд нь ариун цагаан өнгийн бадам цэцэг

суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэн насан хээгээр хөлөөдсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугираг хөх дэвсгэртэй байна. Сүлдний төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэг хийморийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдний хүрээний магнай хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлдсөн ногоон өнгийн уулан хээ, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдлэн сүлжсэн байна.

### 5 дугаар зүйл. Төрийн сүлдийг үйлдэх, дүрслэх

1. Төрийн сүлдийг өнгө ялгах буюу ялгахгүйгээр үйлдэж, дүрслэх болно.

2. Төрийн сүлдийг өнгө ялган үйлдэх буюу дүрслэхэд соёмбо, эрдэнийн хүлэг, түмэн насан хээ, хүрд нь алтан шар, тэнгэр нь хөх, уулан хээ нь тодоос шингэрээж гурваар дагнасан ногоон, бадам цэцэг нь алтан өнгийн хүрээтэй цагаан, хадаг нь алтан шар угсаар хүрээлсэн цэнхэр, чандмань эрдэнэ нь ногоон, улаан, хөх өнгийг дөрвөөр дагнаж алтан шар өнгийн зураасаар хүрээлсэн байна. Төрийн сүлдний чандмань эрдэнэ, түмэн насан хээ, бадам цэцэг нь элгэн хүрэн дэвсгэр дээр байрлана.

3. Төрийн сүлдийг үйлдэх, дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран Үндсэн хуульд хавсаргасан эх загварт эзлсэн тэг, харьцааг чанд баримтлана.

### 6 дугаар зүйл. Төрийн сүлдийг байрлуулах

1. Төрийн сүлдийг:

1) Монгол Улсын Төрийн тамганд;

2) Монгол Улсын хилийн баганаанд;

3) Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хүрэлтийн хайрлаг дээр;

4) Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэцийн хуралдааны болон Төрийн ордны соёмбог танхим, Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөө, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн цэцийн даргын албан тасалгаанд;

5) иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын хуралдааны байранд—хуралдааны хугацаанд;

6) бүх шатны шүүхийн шүүх хуралдааны болон иргэдийн төрөлт, гэрлэлтийг бүртгэх танхимд;

7) Бүх шатны Засаг даргын албан тасалгаанд;

8) Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Монгол Улсын яам, Засгийн газрын үндсэн бүтцэд ордог тусгай газар, иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын тэргүүлэгчид, Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын газрын хаягт;

9) Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэц, иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурал, бүх шатны Засаг дарга, шүүх, прокурор, Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын газрын хэвлэмэл хуудаст;

10) галт тэрэгний зүтгүүр, суудлын вагоны хажуу талд тус тус байрлуулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан танхим, өргөө, албан тасалгаанд байрлуулах Төрийн сүлдийг өнгөөр илгэсэн байна.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад газарт Төрийн сүлдийг байрлуулах асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Монгол Улсын Төрийн туг, түүнийг үйлдэх, байрлуулах, хүндэтгэн залах

7 дугаар зүйл. Төрийн туг

1. Үндсэн хуулийн арван хоёрдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн.

2. Есөн хөлт Их цагаан туг нь Монгол Улсын Төрийн туг мөн.

8 дугаар зүйл. Төрийн тугийг үйлдэх

1. Төрийн тугийг Монгол Улсын бүх аймгийн адуун сургийн дотроос шилж сонгосон цагаан зүсмийн азарганы 80,0 см-ээс доошгүй урттай дэл сүүлээр, ганц хувь үйлдэнэ.

2. Их цагаан тугны нийт өндөр нь ишний хамт 362,0 см, титэм (сэсэм)-ийн тойргийн голч нь 55,0 см, хөд тугны нийт өндөр нь ишний хамт 262,0 см, титмийн тойргийн голч нь 40,0 см байна.

3. Төрийн тугны оройн хэсэгт гангаар сийлсэн, жийжүүдсэн хээтэй, сэрээ хэлбэрийн гилбэр байна. Их Цагаан тугны гилбэрийн үзүүрт дээшээ дүрэлзэж байгаа галын дүрс байрлуулах бөгөөд гилбэр нь тойрсон цэцгийн дэлбээ хэлбэртэй суурь (нар)-тай байна. Уг суурь болон титмийн туурга, гилбэрийн галын дүрсийг монгол дарханы аргаар алтдаж шармалдана.

4. Төрийн туг нь шаргад хээтэй цагаан хоргойгоор хийсэн 4 хэлт манжлага бүхий бүслүүртэй байна. Бүслүүр, хэлийн уулзвар бүр дээр ээс хөөмөл дугуй толь байрлуулна.

5. Их цагаан тугны гилбэрийн өндөр 58,5 см, галын дүрсний өргөн 36,0 см, гилбэр сээсийг холбосон 4 ширхэг ган гархины өндөр 9,5 см, өргөн 7,5 см байна. Титмийн оройд тэнцүү хэмжээтэй 8 ширхэг цэцгийн дэлбээ байна. Их цагаан тугны титмийн туурганы өндөр 10,5 см, дээд, доод хажлаганы өргөн тус бүр 1,3 см, тоарууны тойргийн голч нь 3,5 см, 4 хэлт манжлаганы урт 81,0 см, манжлаганы үзүүрийн улаан хүрэн өнгийн молцогны урт 18,0 см, манжлаганы хэл тус бүрийн дээд хэсгийн өргөн 7,5 см, үзүүр хэсгийн өргөн 10,5 см, бүслүүрийн өргөн 7,5 см, манжлага, бүслүүрийн хүрэн улаан өнгөт эмжээрийн өргөн 1,0 см, хэл, бүслүүрийн уулзвар дахь ээс хөөмөл толсны тойргийн голч нь 9,0 см хэмжээтэй байна.

6. Хөл тугны гилбэрийн өндөр 31,0 см, титмийн туурганы өндөр 9,0 см, дээд, доод хажлаганы өргөн тус бүр 1,0 см, тоарууны тойргийн голч нь 2,5 см, 4 хэлт манжлаганы урт 61,0 см, манжлаганы хэл тус бүрийн дээд хэсгийн өргөн 6,5 см, үзүүр хэсгийн өргөн 9,5 см, бүслүүрийн өргөн 7,0 см, манжлага, бүслүүрийн хүрэн улаан өнгөт эмжээрийн өргөн 0,5 см, хэл, бүслүүрийн уулзвар дахь ээс хөөмөл толсны тойргийн голч нь 7,0 см хэмжээтэй байна.

7. Төрийн тугны ишнийг хус модыг хатааж, тосонд чанаж өнгөлж хийнэ. Их цагаан тугны ишний өндөр нь 303,5 см, голч нь 5,0 см, хөл тугны ишний өндөр нь 231,0 см, голч нь 3,5 см хэмжээтэй байна.

8. Энэ хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Төрийн тугийг дуурайлган үйлдэхийг хориглоно.

#### 9 дүгээр зүйл. Төрийн тугийг байрлуулах

1. Төрийн тугийг өнгийн чулуу шигэтгэж, дотор нь Монгол Улсын бүх аймгийн хөрсний дээжийг байрлуулан цугласан, шаталсан хэлбэртэй хот улсыг бэлэгдсэн хүрээ мөнд-

лын байдалтай суурь дээр залж Төрийн ордонд байрлуулна.

2. Төрийн тугийг газарт хүргэхийг нээрлэнэ.

**10 дугаар зүйл.** Төрийн тугийг хүндэтгэн залгах

1. Монгол ардын хувьсгалын өдөр баяр наадмын Төв талбайд Төрийн тугийг хүндэтгэн зална.

2. Төрийн тугийг хүндэтгэн залгах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

**Монгол Улсын Төрийн далбаа, түүнийг үйлдэх, дүрслэх, мандуулах, байрлуулах**

**11 дүгээр зүйл.** Төрийн далбаа

Үндсэн хуулийн өрнөн хоёрдугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын Төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундах хэсэг нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандаг бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байна. Далбааны ишин талын улаан дэвсгэрийн төв хэсэгт алтан соёмбо байрлуулна. Далбааны өргөн, урт нь 1:2-ын харьцаатай байна.

**12 дугаар зүйл.** Төрийн далбааг үйлдэх

1. Төрийн далбааг улаан, хөх өнгийн хээгүй, цулгүй эдээр үйлдэнэ.

2. Төрийн далбааг үйлдэх, дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран Үндсэн хуульд хайсаргасан эх загварт заасан тэг, өргөн, уртын 1:2-ын харьцааг чанд баримтална.

**13 дугаар зүйл.** Төрийн далбааг мандуулах

1. Төрийн далбааг дараахь газар байнга мандуулна:

1) Монгол Улсын Төрийн ордон;

2) Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн;

3) аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын албан ажлын байр;

4) Монгол Улсад гадаад улс, олон улсын байгууллагад суугаа динломат бодон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын газрын байр.

2. Төрийн далбааг дараахь газар, тээврийн хэрэгсэл дээр түр хугацаагаар мандуулна:



1) Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн өдөр-санал хураах байр;

2) иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын хуралдааны хугацаанд-хуралдааны байр;

3) Монгол Улсын Үндсэн хуулийн болон Монгол Улсыг Бусад Найрамдах Улсаар гунхагласан өдөр-төрийн захиргааны төв байгууллагын байр;

4) Монгол ардын хувьсгалын ойн баярын өдөр-баяр наадмын талбай, төрийн захиргааны төв байгууллага, зэвсэгт хүчин, бусад нэргийн нэгтгэл анги болон хилийн сумангийн байр;

5) Монгол Улсаас гаднаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн болон консулын хөлөгдөж яваа тээврийн хэрэгсэл;

6) хилийн асуудлаар хэлэлцээ хийхээр яваа Монгол Улсын хилийн төлөөлөгчийн хөлөгдөж яваа тээврийн хэрэгсэл.

3. Төрийн далбааг Монгол Улсын бүртгэлтэй усан тээврийн хэрэгсэл дээр олон улсын нийтлэг журмыг баримтлан мандуулна.

4. Олон улсын чанартай буюу үндэсний уламжлалт биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн, наадам, тэлгээртэй адилгах бусад арга хэмжээний үед олон улсын жишиг, ард түмний уламжлалыг харгалзан Төрийн далбааг өргөн мандуулж болно.

**14 дүгээр зүйл.** Төрийн далбааг байрлуулах, дүрслэх

1. Төрийн далбааг дараахь газар байнга байрлуулна:

1) Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүхийн шүүх хуралдааны танхим;

2) Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Үндсэн хуулийн цэцийн даргын албан тасалгаа;

3) бүх шатны Засаг даргын албан тасалгаа;

4) Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суугаа дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн болон худалдааны бүрэн эрхт төлөөлөгч, консулын албан тасалгаа;

5) хилийн төлөөлөгч, хилийн хороо, сумангийн даргын албан тасалгаа.

2. Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг, усан тээврийн хэрэгсэл дээр олон улсын нийтлэг журмыг баримтлан Төрийн далбааг өнгөөр илгэж дүрсэлнэ.

**15 дугаар зүйл.** Төрийн далбааг бэхийлгөх, буулгах.  
Мандаж байгаа Төрийн далбааг орон даяар гашуудал зарласан тохиолдолд 45 хэмээр бэхийлгөх буюу ишний нь гуравны хоёрт хүртэл буулгана.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Монгол Улсын Төрийн тамга, түүнийг үйлдэх, барих, залах, хадгалах

#### 16 дугаар зүйл. Төрийн Тамга

Үндсэн хуулийн арван хоёрдугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар Төрийн тамга нь дөрвөлжин хэлбэртэй, голдоо Төрийн сүлдтэй, сүлдний хоёр талаар Монгол Улс гэсэн бичээстэй, арслангийн дүрс бүхий баруултай байна.

#### 17 дугаар зүйл. Төрийн тамгыг үйлдэх

1. Төрийн тамгыг цул мөнгөөр, гар аргаар, ганц хуш үйлдэнэ.

2. Төрийн тамга нь 10,0x10,0x2,0 см хэмжээтэй, арслангийн дүрс бүхий баруулын өндөр нь 8,0 см байна.

3. Төрийн тамганы дөрвөн өнцөгт бат бэхийг бэлгэдсэн холбоо түмэн насан хээ байрлуулан, Монгол Улс гэсэн бичээсийг монгол үсгээр эвхэж бичсэн байна.

4. Төрийн тамгыг дуурайлган үйлдэхийг хориглоно.

#### 18 дугаар зүйл. Төрийн тамгыг барих, байрлуулах

1. Төрийн тамгыг Монгол Улсын Ерөнхийлөгч барина.

2. Төрийн тамгыг:

1) Монгол Улсын Үндсэн хуулийн уг эхийн хуудас бүр дээр;

2) Монгол Улсын хууль, Улсын Их Хурлаар соёрхон баталсан олон улсын гэрээ, Монгол Улсаас гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах тухай Улсын Их Хурлын шийдвэрийн уг эхийн эхний хуудас дээр тус тус дарна.

3. Төрийн тамгыг үндэсний хээгээр чимэглэсэн мөнгөн тоног бүхий, зөөлөн торгомсог эдээр доторлосон зандаг модон хайрцагт байрлуулана.

#### 19 дүгээр зүйл. Төрийн тамгыг залах, хадгалах

Төрийн тамгыг залах журмыг Улсын Их Хурал, хадгалах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Монгол Улсын Төрийн дуулал, түүнийг эгшиглүүлэх, хүндэтгэх

**20 дугаар зүйл.** Төрийн дуулал

Монгол Улсын Төрийн дуулал нь энэ хуульд хавсаргасан үг, аятай байна.

**21 дүгээр зүйл.** Төрийн дууллыг эгшиглүүлэх

1. Төрийн дууллыг дараахь тохиолдолд эгшиглүүлнэ:

1) Төрийн тугийг хүндэтгэн залах ёслол үйлдэхэд;

2) Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн тангараг өргөсний дараа;

3) Монголын ард түмний баяр ёслолд зориулсан баярын хурал, цуглаан, ёслолын ажиллагааг нээхэд;

4) Монгол Улсын түүхэнд холбогдох болон эх орон, ард түмнийхээ өмнө гарамтай гавьяа байгуулсан хүмүүсийн дурсгалд зориулсан хөшөө, цогцолборыг нээхэд;

5) радио өргөн нэвтрүүлгийн үндсэн хөтөлбөр эхлэх, төгсөхөд;

6) бүх ард түмний баяр ёслолд зориулсан телевизийн хөтөлбөрийн анхны өдрийн нэвтрүүлэг эхлэхэд;

7) хууль тогтоомжид заасан бусад тохиолдолд.

2. Олон улсын чанартай биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн, наадам, тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээний үед олон улсын жишгийг баримтлан Төрийн дууллыг эгшиглүүлж болно.

3. Төрийн дууллыг найрал, үлээвэр хөгжим, дуу бичлэгийн хэрэгсэл ашиглан эгшиглүүлэх буюу найрал дуу, найрал дуу-хөгжим зэрэг бусад хэлбэрээр дуулж, хөгжимдөж болно.

4. Төрийн дууллыг энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 5-д заасан тохиолдолд бүрэн хэмжээгээр, бусад тохиолдолд эхний бадгийг дахилтын хамт эгшиглүүлнэ.

5. Цэргийн анги, нэгтгэлд Төрийн дууллыг эгшиглүүлэх журмыг цэргийн дүрмээр зохицуулна.

**22 дугаар зүйл.** Төрийн дууллыг хүндэтгэх

Төрийн дууллыг олон нийтийн өмнө эгшиглүүлэхэд оролцогч бүх хүн босож хүндэтгэнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

23 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдгийн дүрсэлэх, үйлэлэх зөвшөөрөл

1. Төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зурагт хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрсэлэх зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар тогтооно.

2. Төрийн тугийг кино, уран сайхны бусад арга хэмжээнд зориулан дуурайлган үйлдэх зөвшөөрлийг Засгийн газар тухай бүр олгоно.

24 дүгээр зүйл. Төрийн ёслол, хүндэтгэлийн үед  
Төрийн бэлгэ тэмдгийг хэрэглэх

Монгол Улсын төр, засгийн тэргүүн нар гадаад оронд, гадаад орны төр, засгийн тэргүүн нар Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх, гадаад орноос Монгол Улсад суух элчин сайд итгэмжлэх жуух бичиг барих, түүнчлэн төрийн ёслол, хүндэтгэлийн бусад арга хэмжээний үед Төрийн сүлд, далбааг дээдлэн хэрэглэх, Төрийн дууллыг эгшиглүүлэх журмыг Монгол Улсын Төрийн ёслолын тухай хууль тогтоомжоор тодорхойлно.

25 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдэг хэрэглэх эрх чөлөө

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллаага нь төрийн бэлгэ тэмдгээ гүнээ дээдлэн хүндэтгэж, бүх ард түмний баяр наадам, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ болон бусад үед Төрийн сүлд, далбаагаа барих, байрлуулах, мандуулах буюу Төрийн дууллыг эгшиглүүлж болно.

26 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдгийг гутаан  
доромжлохыг хориглох

Төрийн бэлгэ тэмдгийг гутаан доромжлохыг хориглоно.

27 дугаар зүйл. Харвицлага

1. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 3, 8 дугаар зүйлийн 8, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг санаатайгаар зорссон бол 5000—10000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Засгийн газраас тогтоосон журмыг зөрчиж Төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зурагт хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрсэлсэн,

Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр Төрийн тугийг кино, уран сайхны бусад арга хэмжээнд зориулан дуурайлган үйлдсэн, эсхүл Төрийн бэлгэ тэмдгийг санаатайгаар гуйвуулан өөрчлөх, устгах, гэмтээх зэргээр гутаан доромжилсон бол 10000—25000 төгрөгөөр торгох, эсхүл 14—30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуула.

3. Торгох шийтгэлийг шүүгч, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах, баривчлах шийтгэлийг шүүгч ногдуула.

**28 дугаар зүйл. Хуулийн биелэлтэд тавих хяналт**

Энэ хуулийн биелэлтэд тавих хяналтыг бүх шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага, гадаад харилцаа болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хилийн цэргийг удирдах газар хэрэгжүүлнэ.

**29 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

Энэ хуулийг 1994 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай  
Монгол Улсын хуулийн хавсралт № 1

Үгийг Ц. Дамдинсүрэн  
Авыг Б. Дамдинсүрэн  
Л.Мөрдөрж

## МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДУУЛАЛ

Дархан манай хувьсгалт улс  
Даяар Монголын ариун голомт  
Дайсны мөлд хэзээ ч орохгүй  
Дагдал энхжиж үүрд мөнхжино

Хамаг дэлхийн шударга улстай  
Хамтран нэгдсэн эгнээг бэхжүүлж  
Хятад зориг, бүхий чадлаараа  
Хайрт Монгол орноо мандуулъя

Зоригт Монголын золтой ардууд  
Зовлонг тонилгож, жаргалаг эдлэн  
Жаргалаг түлхүүр, хөгжлийн тулгуур  
Жавхланта манай орон мандтугай

Хамаг дэлхийн шударга улстай  
Хамтран нэгдсэн эгнээг бэхжүүлж  
Хятад зориг, бүхий чадлаараа  
Хайрт Монгол орноо мандуулъя

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДУУЛАЛ

Үгийг Ц. Дамдинсүрэн

Ашиг Б. Дамдинсүрэн  
Л. Мөрдөрж

Монгол улс

1. ДЭЛ - ХАН ИЭ - НЭЙ ХУНС - ЛЭГЭГ Ү - С (У)С  
 2. ДЭ - ХЭГТ МОН - ГО - ЛЫН ТЭГ - ХЭР 4Р - АХУА

ДЭ - ХЭР МОНГО - ЛЫН Д - РҮМ ТУ - СЕМ - С (С)С  
 ДЭ - ХЭГТ ТӨ - НИТ - ГЭЖ ХЭРГЭ - ХЭГ ЭД - ХЭМ

ДЭЛ - ХАН ХУНС ДЭГ - ХЭГ О - СОН - ГУР  
 ХЭРГЭ - ЛЫН ТҮР - ГҮҮР ХӨГЖ - ЛЭН ТҮГ - ГҮҮР

ДЭГ - ХЭГ ДЭГ - ХЭГ ҮҮС МОН - Х (Н) - С  
 ХЭРГЭ - ЛЭН ХЭН - ДЭ С - СОН ХЭМД - ХҮ - ГЭР

ХЭМ - ИГ ДЭГ - ХЭН ХУА - ХӨГЖ Ү - Х (А)С - ТЭР

ХЭМ - ДЭГ ХЭМД - СОН ТУ - ХЭГ ДЭГ - ХҮҮР - ХЭМ

ХЭ - ЛЭН ДЭ - ХЭГ БҮ - ХЭН ХЭМД - ХЭМ - ХЭМ

ХЭМ - ХЭМ МОН - ГОЛ ХЭМ - ХЭМ ХЭМ - ДУУГА -

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН  
ТОГТООЛ

1994 оны 4 дүгээр  
сарын 26-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар  
хот

ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ  
БҮРЭН ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. «Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ»-нд Монгол Улсыг төлөөлж гарын үсэг зурах бүрэн эрхийг Монгол Улсын Ерөнхий сайд Пунцагийн Жасрайд олгосугай.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН  
ТОГТООЛ**

1994 оны 4 дүгээр  
сарын 29-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар  
хот

**ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Судалгааны төвийн дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

Дарга

**Н. БАГАБАНДИ**

Улсын Их Хурлын 1994 оны 30-р  
тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ДЭРГЭДЭХ  
СУДАЛГААНЫ ТӨВИЙН ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Судалгааны төв (цаашид «төв» гэх) нь Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах болон бусад бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсонгуй болгох, хууль тогтоомжийн үр нөлөөг дээшлүүлэх, батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийн улс төр, нийгэм, сэтгэл зүйн үр дагавар зэрэг асуудлаар судалгааны ажил эрхэлж Улсын Их Хурлыг мэдээллээр хангах зорилго бүхий судалгааны байгууллага мөн;

2. Төвийн захирал нь төвийн үйл ажиллагааг Улсын Их Хурлын Байнгын хороо, ажлын хэсэг, Улсын Их Хурал дахь намын бүлэг болон нутгийн захиргааны байгууллагын үйл

ажиллагаатай уялдуулан зохицуулах асуудлыг Улсын Их Хурлын дэд даргатай, УИХ-ын Тэмгэн газрын мэдээлэл-лолдамжийн албан болон бусад хэлтэс, албатай уялдуулах асуудлыг Тэмгэн газрын Ерөнхий нарийн бичгийн даргатай тус тус зохицолон шийдвэрлэнэ.

3. Төв нь хуулийн этгээд мөн бөгөөд зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

### Хоёр. Төвийн зохион байгуулалт, эрх, үүрэг

4. Төв нь улсын төсвөөс санхүүжих бөгөөд төслийн шууд захирагч нь төвийн захирал байна.

5. Төв нь төсвөө бие даан боловсруулж Улсын Их Хурлын төсөвт тусгана. Төвийн төсөв, түүний гүйцэтгэлд Улсын Их Хурлын Дотоод асуудлын байнгын хороо хяналт тавина.

6. Төвийн захирал нь төвийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө харууна.

7. Төвийн захирлыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилно. Төвийн захирал нь энэ дүрмийн 12-т заасан шаардлагыг хангасан байна.

8. Төвийн захирал төвийнхээ боловсон хүчний асуудлыг бие даан шийдвэрлэнэ.

9. Төвийн захирал нь эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.

10. Төв нь тухайн жилд гүйцэтгэх судалгааны ажлын чиглэлээ Улсын Их Хурлын Байнгын хороодын ажлын чиглэлтэй уялдуулан тодорхойлож байна.

11. Төвийн ажилтнуудын цалингийн хэмжээг судалгааны ажлын туршаага, дадлага тухайн жилд гүйцэтгэсэн ажлын үр дүнг үндэслэн төрийн эрх барих дээд байгууллагын дэргэдэх судалгааны байгууллагын ажлын онцлогийг харгалзан төсөвтөө багтаан төвийн захирал тогтооно.

12. Төвийн ажилтнаар судалгааны ажил бие даан явуулах дадлага, чадвар, эрамын зэрэг, цол, гадаад хэлний зохих бэлтгэлтэй хүнийг сонгон шалгаруулж ажиллуулана.

13. Төв нь дараахь үүрэг гүйцэтгэнэ:

1) Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах чиг үүргийн хэрэгжилт, тэдгээрийг боловсронгуй болгох арга зам зэрэг асуудлаар судалгааны ажлыг хийж Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж байгаа болон хэлэлцүүлэхээр бэлтгэж буй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдийг шаардлагатай судалгааны материалаар хангах;

2) хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх ажилд ажиглаат, судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт, нөхцөлөө гаргах, хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний улс төрийн болон нийтэм-сэтгэл зүйн үр дагаврыг судалж санал, зөвлөмж гаргах;

3) төрийн тогтолцооны төлөвшил, хөгжил, төрийн бодлого болон эрх зүйн шинэчлэлийн асуудлаар улсын хэмжээнд явуулсан судалгааны үр дүн болон гэдлэд орнуудын хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагааны туршлагын талаар нэгтгэсэн судалгааны мэдээлэл гаргах;

4) олон нийтийн санаа бодол илэрхийлэх социологийн судалгаа явуулж, нийгмийн үйл явцад дүн шинжилгээ хийх;

5) судалгааны ажлын явц, завсрын болон эцсийн үр дүнгийн талаарх мэдээлэл, лавлагаа, саналыг тэдгээрийн ач холбогдлыг харгалзан тогтоосон зэрэглэлийн дагуу Улсын Их Хурлын гишүүн, бусад холбогдох албан тушаалтанд танилцуулах, хэлэлцэж, мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах;

6) хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг олон нийтэд сурталчлах ажилд оролцох;

7) төвийн ажилтны эрх, үүрэг, ажлалах журмыг тусгасан дотоод журам боловсруулан баталж мөрдөх.

14. Төв нь дараахь эрхтэй байна:

1) төвийн судалгааны ажилд шаардагдах мэдээ, материал, тоо баримтыг холбогдох байгууллага, албан тушаалтнаас зохих журмын дагуу авч ашиглах;

2) яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг Тэргүүлэгчдийг түшиглэн орон тооны бус хэсэг ажилдуулах, олон нийтийн санаа бодол судлах зэргээр мэдээлэл авч нэгтгэн боловсруулах;

3) судалгааны ажилд бусад байгууллагын эрдэмтэн, мэргэжилтнийг гэрээгээр оролцуулах, судалгааны ажлын захиалга өгч бусад байгууллагаар гүйцэтгүүлэх;

4) судалгааны нууцал мэдээлэл, бүтээл, Улсын Их Хурлыг мэдээллээр хангахад шаардлагатай бусад материалыг эхлүүлэх;

5) судалгааны ажлын үр дүнг түшиглэн хурал, семинар, уулзалт, ярилцлага зохион байгуулах;

6) судалгааны ажилтныг эрдмийн зэрэг горилогчоор батлуулах, аспирантур, докторантур элсүүлэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

7) гадаад орны парламентын дэргэдэх эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай харилцаа тогтоож хамтран ажиллах.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 4 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 31

Улаанбаатар  
хот

### АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд бөрчлөлт оруулан боловсруулах Улсын Их Хурлын ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

- 1) А. Болат — Улсын Их Хурлын гишүүн,  
Хурал, захиргааны байгын  
хорооны дарга

Гишүүд:

- 2) Ж. Болдбаатар — Улсын Их Хурлын гишүүн  
3) Ж. Бямбадорж — Улсын Их Хурлын гишүүн  
4) А. Ганбаатар — Улсын Их Хурлын гишүүн  
5) М. Далайхүү — Улсын Их Хурлын гишүүн  
6) С. Зориг — Улсын Их Хурлын гишүүн  
7) Ч. Зоригтбаатар — Улсын Их Хурлын гишүүн  
8) Ц. Товуусүрэн — Улсын Их Хурлын гишүүн  
9) Н. Лувсанжав — Засгийн газрын гишүүн,  
Хууль зүйн сайд  
10) Б. Энхмандах — Монгол Ардын Хувьсгалт  
Намын нарийн бичгийн  
дарга

- |                  |  |
|------------------|--|
| 11) Даш, Ганболд | — Монголын Үндэсний Ардчилсан Намын Ерөнхий зөвлөлийн гишүүн |
| 12) Н. Алтанхуяг | — Монголын Социал Демократ Намын дэд дарга                   |
| 13) М. Ганбат    | — Монголын Ногоон намын Бага хурлын гишүүн                   |
| 14) Ц. Баярсүрэн | — Монголын Шашинтны Ардчилсан Намын дарга                    |
| 15) П. Зориг     | — Монголын Хөрөнгөтний Намын удирдах зөвлөлийн гишүүн        |
| 16) Х. Пүрэв     | — Монголын Ажилчны Нэгдсэн Намын дарга                       |
| 17) Д. Зоригт    | — Монголын Уламжлалын Нэгдсэн Намын дэд дарга                |
| 18) Л. Байсгалан | — Монголын Ардын Намын гишүүн                                |

Дарга

Н. БАГАБАЦДИ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1994 оны 5 дугаар  
сарын 6-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар  
хот

### АЙМАГ, СУМ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дархан хотын одоогийн хилийн цэсээр тодорхойлогдсон нутаг дэвсгэрт Дархан-Уул аймаг байгуулж, төвийг нь Дархан гэж нэрлэсүгэй.

2. Хуучин Дархан хотын хороодыг дор дурдсанаар өөрчилж Дархан-Уул аймгийн дараахь сум байгуулсугай:

а) Дархан, Найрамдал хорооны нутаг дэвсгэрт Дархан-Уул аймгийн Дархан сум байгуулж, төвийг нь Дархан гэж нэрлэсүгэй;

б) Шарын гол хороог Дархан-Уул аймгийн Шарын гол сум болгож төвийг нь Шарын гол гэж нэрлэсүгэй;

в) Орхон хороог Дархан-Уул аймгийн Орхон сум болгож төвийг нь Орхон гэж нэрлэсүгэй;

г) Хөнгөр, Салхит хорооны нутаг дэвсгэрт Дархан-Уул аймгийн Хөнгөр сум байгуулж төвийг нь Буурал гэж нэрлэсүгэй;

3. Дархан-Уул аймгийн Дархан, Шарын гол, Хөнгөр, Орхон сумын хилийн цэсийг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

4. Эрдэнэт хотын одоогийн хилийн цэсээр тодорхойлогдсон нутаг дэвсгэрт Орхон аймаг байгуулж, төвийг нь Эрдэнэт гэж нэрлэсүгэй.

5. Хуучин Эрдэнэт хотын хороодыг дор дурдсанаар өөрчилж Орхон аймгийн дараахь сум байгуулсугай:

а) Найрамдал, Баян-Өндөр хорооны нутаг дэвсгэрт Орхон аймгийн Баян-Өндөр сум байгуулж, төвийг нь Эрдэнэт гэж нэрлэсүгэй;

б) Жаргалант хороог Орхон аймгийн Жаргалант сум болгож төвийг нь Жаргалант гэж нэрлэсүгэй.

6. Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын хилийн цэсийг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

7. Чойр хотын одоогийн хилийн цэсээр тодорхойлогдсон нутаг дэвсгэрт Говь-Сүмбэр аймаг байгуулж, төвийг нь Чойр гэж нэрлэсүгэй.

8. Хуучин Чойр хотын хороодыг дор дурдсанаар өөрчилж Говь-Сүмбэр аймгийн дараахь сум байгуулсугай:

а) Сүмбэр хороог Говь-сүмбэр аймгийн Сүмбэр сум болгож төвийг нь Чойр гэж нэрлэсүгэй;

б) Баянтал хороог Говь-Сүмбэр аймгийн Баянтал сум болгож төвийг нь Лүн гэж нэрлэсүгэй;

в) Шивээговь хороог Говь-сүмбэр аймгийн Шивээговь сум болгож төвийг нь Сэвхүүд гэж нэрлэсүгэй.

9. Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын хилийн цэсийг 3 дугаар хавсралт ёсоор баталсугай.

10. Шивээр байгуулсан аймэг сумын иргэдийн Нийтийн болон Төлөөлөгчдийн хурлыг шинэчлэн байгуулах. Засаг дарга нарыг томилж, гэлгээрийн Тамгын газрыг эмхлэн байгуулах, түүний бүтэц, орон тооны хязгарыг нэвчлэн буюу нэг мянгаар тогтоох асуудлыг 1994 оны эхний хагаст багтаан зохион байгуулахыг Засгийн газарт дэлгэсугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1994 оны 5 дугаар  
сарын 6-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар  
хот

### СУМ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дэх тэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх тэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн төв хотуудын одоогийн хилийн цэсээр хилийн цэс нь тодорхойлогдох нутаг дэвсгэрт дараахь сумдыг байгуулж төвийг нь дор дурдсанаар нэрлэсүгэй:

1) Архангай аймгийн төвд Эрдэнэбулган сум, төвийг Цэцэрлэг;

2) Баян-Өлгий аймгийн төвд Өлгий сум, төвийг Өлгий;

3) Баянхонгор аймгийн төвд Баянхонгор сум, төвийг Баянхонгор;

4) Булган аймгийн төвд Булган сум, төвийг Булган;

5) Говь-Алтай аймгийн төвд Есөнбулаг сум, төвийг Алтай;

6) Дорноговь аймгийн төвд Сайншанд сум, төвийг Сайншанд;

7) Дорнод аймгийн төвд Хэрлэн сум, төвийг Чойбалсан;

8) Дундговь аймгийн төвд Мандалговь сум, төвийг Мандалговь;

9) Завхан аймгийн төвд Улиастай сум, төвийг Улиастай;

10) Өвөрхангай аймгийн төвд Арвайхээр сум, төвийг Арвайхээр;

11) Өмнөговь аймгийн төвд Даланзадгад сум, төвийг Даланзадгад;

12) Сүхбаатар аймгийн төвд Баруун-Урт сум, төвийг Баруун-Урт;

13) Сэлэнгэ аймгийн төвд Сүхбаатар сум, төвийг Сүхбаатар;

14) Төв аймгийн төвд Зуунмод сум, төвийг Зуунмод;

15) Увс аймгийн төвд Улаангом сум, төвийг Улаангом;

16) Ховд аймгийн төвд Жаргалант сум, төвийг Ховд;

17) Хөвсгөд аймгийн төвд Мөрөн сум, төвийг Мөрөн;

18) Хэнтий аймгийн төвд Өндөрхаан сум, төвийг Өндөрхаан.

2. Монгол Улсын Засгийн газарт даалгах нь:

а) энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан сумдын иргэдийн нийтийн болон Төлөөлөгчдийн Хурлыг байгуулах, тэдгээрийн Засаг дарга нарыг томилох арга хэмжээг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу энэ оны эхний хагаст багтаан тохион байгуулсугай;

б) Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 10 дугаар зүйлд заасныг үндэслэн аймгийн төв хотуудад зэрэглэл тогтоох, хотын захирагчийн сонгууль явуулах, ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох, хотын зөвлөл байгуулах асуудлыг энэ оны эхний хагаст багтаан шийдвэрлэсүгэй.

3. Аймгийн төв хотуудын нутаг дэвсгэрт сум байгуулсантай холбогдуулан Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, зарлигийн заалтыг хавсралтын ёсоор хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Их Хурлын 1994 оны  
33 дугаар тогтоолын хавсралт

ХУВИНГУЙ БОЛСОНД ТООЦОХ БНМАУ-ЫН  
АРДЫН ИХ ХУРАЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ЗАРЛИГ, ЗАРЛИГИЙН ЗААЛУУД

1. «Хотын тодорхойлолтын тухай» Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1961 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 136 дугаар зарлигийн 11 дүгээр заалт.

2. «Сэлэнгэ аймаг байгуулах тухай» Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1959 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 222 дугаар зарлигийн 2 дугаар заалт.

3. «Чойбалсан аймагт хотын ба хороо захиргаа байгуулах тухай» Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1960 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 253 дугаар зарлиг.

4. «Хот болгох тухай» Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1963 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 169 дүгээр зарлиг.

5. «Хот болгох тухай» Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1963 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 196 дугаар зарлиг.

6. «Өмнөговь, Дундговь, Төв, Сүхбаатар аймгийн төвийг хот болгох тухай» Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 124 дүгээр зарлиг.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1994 оны 5 дугаар

Догоор 34

Улаанбаатар

сарын 6-ны өдөр

дэг

### СУМ БАЙГУУЛАХ ТУХАН

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хөвсгөл аймгийн Ханх хороог татан буулгаж, тус хорооны нутаг дэвсгэрт Ханх сум байгуулж, төвийг нь «Турт» гэж нэрлэсүгэй.

2. Дорноговь аймгийн Замын-Үүд хороог татан буулгаж, тус хорооны нутаг дэвсгэрт Замын-Үүд сум байгуулж, төвийг нь «Борхойн тал» гэж нэрлэсүгэй.

3. Хөвсгөл аймгийн Ханх сум, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хилийн цэсийг 1 дүгээр хавсралтын ёсоор баталж, дээрх сумдыг байгуулсантай холбогдуулан Хөвсгөл аймгийн Ринчинлхүмбэ, Дорноговь аймгийн Эрдэнэ, Улаанбадрах, Сайншанд сумын хилийн цэсийг 2 дугаар хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

4. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Ханх, Замын-Үүд, сумын иргэдийн Нийтийн болон Төлөөлөгчдийн Хурлиг байгуулах, зохих шаарцааг засаг даргыг томилдох ажлыг 1994 оны эхний хагаст багтаан зохион байгуулахыг Засгийн газарт даалгасугай.

5. Нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн батлах тухай Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 75 дугаар зарлигийн 2 дугаар хавсралтын 88, 91, 261 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын 1974 оны  
34 дүгээр тогтоолын 1 дүгээр хавс-  
раат

### ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ СУМ, ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН ХИЛИЙН ЦЭС

#### 1. Хөвсгөл аймгийн Ханх сумын хилийн цэс:

(2988,0) тоот улсын хилээр, Хэвэн залуу үүрний нуруу-гаар улсын хилээс гарч 2322,4, 2431,0, 2373,9 тоотуудаар хир-лин Их хур модны голын зүүн эргээр уруудаж, Зүрхийн ба-руун гол-Их хур модны голын уулзвар, Хойт бага тагийн даваа (2192,5), Урд бага тагийн даваа, 2168,8; 2168,3 тоо-тууд, Ганш уулын даваа, 2202,6 тоот, Цагаан-Уул (2278,2), Хуштын даваа, Далбайн эхний даваа, Хур модны сарьдгийн нуур, 2081,9 тоот, Өрлийн голын эхээр ярлаж, Цагаан-Уул (2357,9), Сэнтийн даваа, Хэц өврийн давааны тушаа Хөвсгөл нуурт хүрч нуурын хөрөөгөөр, Алаг царын голын адаг (1645,2), нуурын урд талаар захлан тойрч Хилэнт нуурын хойт үзүүрийг дайран нуураа хөвөөлж Хөвсгөл нуур-Өлгий голын уулзвар (1645,2), Өлийн голоо өгсөн Өлийн даваа, Нүнгэн өлийн даваа 2783,0; 2730,0; 2966,0; 2907,0; 2823,0; 2969,0; 2995,0 тоотууд, Ухаа мунгараг (2830,0), Ламбиштик (3130,0), 2966,0, 2735,0 тоотууд, Эмээл-Уул (2639,0), Ямаат (2559,0), 2465,0 тоот улсын хилийн 2988,0 тоот.

#### 2. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хилийн цэс:

Төмөр замын 1085 дахь км, Улаан-Оноо (1115,0), улсын хилийн 361 дүгээр багана, улсын хилээр 354 дүгээр багана, Улаан-Онооны бууц, Хамуутын худаг, Төмөр замын 1085 дахь км.

Монгол Улсын Их Хурлын 1993 оны  
34 дүгээр тогтоолын 2 дугаар хэсэг-  
рэлт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РЭНЧИНАХУМБЭ, ДОРНОГОВЬ  
АЙМГИЙН ЭРДЭНЭ, УЛААНБАДРАХ, САЙНШАНД  
СУМЫН ХИЛИЙН ЦЭС

1. Хөвсгөл аймгийн Рэнчинлахумбэ сумын хилийн цэс:

(2897,4) тоот улсын хилээр, 2988,0; 2465,0 тоотууд, Ямаат (2559,0), Эмээл-Уул (2639,0), 2735,0; 2966,0 тоотууд, Лам-биштинг (3130,0), Ухаа мунгорог (2830,0), 2995,0; 2969,0; 2823,0; 2907,0; 2966,0; 2730,0; 2783,0 тоотууд, Нүүцгэн өлийн даваа, Өлийн даваа, Өлийн голоо уруудаж Хөвсгөл нуур-Өлийн голын уулзвар (1645,2) нуурын баруун захар хөвөөлж Хилэнт нуурын хойт үзүүр, Хөх өвс уул (2648,2), 2569,0; 2578,0 тоотууд, Их-Уул (2961,2), 2518,8 тоот, Өлхөний даваа, Өлхөн сайрын баруун эргээр уруудаж, Хар чулуут-Өлхөн сайрын уулзвар, Хар чулуут голын хойт эргээр өгсөж, Хар чулуут-Зосын голын уулзвар, Зосын голын урд хяраар хярааж, Хар чулуут уул (2516,4), 2352,1; 2351,2; 2493,4 тоотууд, Ачит-Уул (2622,1), 2516,2 тоот, Бадарчийн дүх (2162,8), 2247,2; 2478,8; 2448,7 тоотууд, Сэрх-Уул (2744,0), 2471,9 тоот, Их хар толгой (2439,3), 2763,6; 2778,3; 2850,7; 2803,1; 2548,9; 3101,8 тоотууд, Өвөр босготын улаан хад (2857,4), 3001,7; 2933,4, 2765,9 тоотууд, Алхван гозгор, алхван сайрыг уруудаж, 1561,1 тоот, Шүүрэгт (1738,9), Их турууны булаг, Хатирын голын баруун эргээр уруудаж, Дээд-овоо (1560,8), Сантын-Овоо (1640,8), Дээд цахир уул (1805,4), Дээд цахир, уулын баруун үзүүр, Хөгийн голын зүүн эргээр өгсөн, Өндөр модны гарам, Хирлэнт (Хэргэнэгийн таг), (2183,9), Байнголын их даваа, Байнголын дунд даваа, Байн-Эрээний нурууны 2297,1, 2504,5 тоотууд, Эвтийн даваа (2292,0), Тэрэгтэгийн даваа (1830,0), Хар чулуутын таг (2032,5), Дунд давааны урд өндөр, Дунд давааны баруун хамрын үзүүр хүрч, Доод нуурын зүүн эргээр Шинихид-Цагга голын уулзвар, Мухар цайга-Цагга голын уулзвар, 2194,0 тоот, Эрээний хяр (2185,8), 2257,8 тоот Сүрэнхшинг уул (2554,0), 2690,5 тоот, Шинихид гадар-Өөсийн голын уулзвар, Ханагайн цагаан хад (2244,0), 2063,9 тоот, Их-Уул (2046,0), Рэнчинлахумбэ уул (2622,7), Хэвтээ толгой (2005,1), Хуурай сайр, Гани уулын хар нуур (1802,0), Гани уул, Хар даваа

(1834,2), 1921,0 Шаргын гол, Хавтгайн голын уулзаар, Шаргын ганц уул (1968,8), Хонгин таг (2786,0), Их бэлчирийн тэгсөр (2924,0), улсын хилийн 2897,4.

2. Дорноговь аймгийн Эрдэнэ сумын хилийн цэс:

Хамарын хурлын туурь, Хадан хушууны хулаг, аман усны хулаг, Енийн овоо (1055,6), Цагаан толгойн хулаг 1053,9; 1054,2; 1020,9 тоотууд, улсын хилийн 379 дүгээр багана (1012,7), улсын хилээр 361 дүгээр багана, Улаан-Овоо (1115,0), төмөр замын 1085 дахь км, Хамуутын хулаг, Улаан-Овооны бууц, улсын хилийн 354 дүгээр багана, улсын хилээр 349 дүгээр багана, 1103,4 тоот, Зааны улаан тойром, нарийн цагаан овоо (1032,8), Жаргалантын адгийн ус хулаг, Оргихын хулаг Цэвүүн хонгорын овоо, Завгийн хулаг, Хар дов (1085,0), Далайн хулаг, Жаргалантын хулаг, машин замаар өргөн сумын туурь, Хамарын хурлын туурь.

3. Дорноговь аймгийн Улаанбадрах сумын хилийн цэс:

914,4 тоот, Гурван сүхайн хулаг, 834,5; 796,9 тоотууд, Хар тээг (772,4), 771,0; 703,0; 714,0; 716,0 тоотууд, Далайн түрүүгийн зүүн ухаа (803,9); 780,2; 784,0, 734,0, 806,7 тоотууд, Өргөн сумын туурь, машины зам дагуу Жаргалантын хулаг, Далайн хулаг, Хар дов (1085,0), Завгийн хулаг, Цэвүүн хонгорын овоо, Оргихын хулаг, Жаргалантын адгийн ус хулаг, Нарийн цагаан овоо (1032,8), Зааны улаан тойром, 1103,4 тоот, улсын хилийн 349 дүгээр багана, Улсын хилээр Эрдэнэцогтын овоо (1158,4), 1205,2 тоот, Цагаан-овооны хурлын туурь, Улаан дуурын хойт булан, Хярлангийн дэрсэн усан хулаг, Ихэр шандын хулаг, Эрсийн ус хулаг, Зангуут баян усны хулаг, Өлийн овоо (1024,6), 1148,9 тоот, Замын гүн хулаг, Сайгийн далай хулаг, Сайншанд хулаг, Эрэг модон шандын хулаг, мөргөцгийн хулаг, Номгон (838,4), говийн шанд усны хулаг, 817 тоот, Аравын шинэ ус, 914,4 тоот.

4. Дорноговь аймгийн Сайншанд сумын хилийн цэс:

982,9; 914,6 (4 дүгээр шон), 1035,5 (6 дугаар шон), 895,0 (1 дүгээр шон), Зэгийн овоо (668,1), 883,9; 828,9 тоотууд, Сэнзүүлийн хулаг, Хамарын хурлын туурь, Өргөн сумын туурь, 806,7; 734,0; 784,0; 780,2 тоотууд, Далайн түрүүгийн зүүн ухаан (803,9), 716,6; 714,0; 703,0; 771,0 тоотууд, Хар тээг (772,4), 796,9, 834,5 тоотууд, Гурван сайхан хулаг, 914,4 тоот, Цагаан дүх (1048,0), Баруун төгрөгийн хулаг, 1010,1; 982,9

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

1994 оны 5 дугаар

Дугаар 35

Урьдчилсан

сарын 6-ны өдөр

дүг

ЗАРИМ ХОТЫН ХОРООГ ТАТАН БУУЛГАХ  
ТУХАН

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хуучин Эрдэнэт хотын Хялганат хороог татан буулгаж, Будган аймгийн Хангал суманд нэгтгэн харьяалуусугтай,
2. Хуучин Дархан хотын Хөтөл хороог татан буулгаж, Сэлэнгэ аймгийн Сайхан суманд нэгтгэн харьяалуусугтай.
3. Хялганат, Хөтөл хороог татан буулгасантай холбогдуудан иргэдийн Нийтийн Хурлыг шинэчлэн байгуулах, Засаг дарга нарыг томилж ажлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу зохион байгуулан явуулахыг Засгийн гэээрт даалгасугтай.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАМЫН  
ТОГТООЛ

1994 оны 5 дугаар

сэдэв 6-ыг өдөр

Дугаар 36

Улаанбаатар

хот

ЗАРИМ ХОТ, ХОРООДЫГ СУМДАД НЭГТГЭХ  
ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн дөрөв-дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1. Дор дурдсан хот, хороодыг засаг захиргааны хувьд тухайн суманд нэгтгэн харьяалуулсугай:

1) Баян-Өлгий аймгийн Цагааннуур хороог татан буулгаж мөн аймгийн Ногооонуур суманд;

2) Булган аймгийн Өдэгийг хороог татан буулгаж мөн аймгийн Орхон суманд;

3) Говь-Алтай аймгийн Гуулин хороог татан буулгаж мөн аймгийн Дэлгэр суманд;

4) Дорноговь аймгийн Зүүнбаян, Сайншанд (Ар) хороодыг татан буулгаж, мөн аймгийн Сайншанд суманд;

5) Дорноговь аймгийн Хажуу-Улаан хороог татан буулгаж мөн аймгийн Иххэт суманд;

6) Дорнод аймгийн Эрээн хороог татан буулгаж мөн аймгийн Баян-Уул суманд;

7) Завхан аймгийн Тосонцэнгэл хотыг Булнай суманд;

8) Өвөрхангай аймгийн Дөдгөөн хороог татан буулгаж мөн аймгийн Зүүнбаян-Улаан суманд;

9) Өвөрхангай аймгийн Баянтээг хороог татан буулгаж мөн аймгийн Нарийнтээл суманд;

10) Өвөрхангай аймгийн Их-Уул хороог татан буулгаж мөн аймгийн Арвайхээр суманд;

11) Сүхбаатар аймгийн Бүрэнцогт хороог татан буулгаж мөн аймгийн Мөнххаан суманд;

12) Сэлэнгэ аймгийн Түнхэл хороог татан буулгаж мөн аймгийн Мэндал суманд;

13) Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотыг мөн аймгийн Мандал суманд;

14) Сэлэнгэ аймгийн Дулаанхаан хороог татан буулгаж мөн аймгийн Шаамар суманд;

15) Хөвсгөл аймгийн Хатгал хотыг мөн аймгийн Алаг-Эрдэнэ суманд;

16) Хэнтий аймгийн Бэрх хороог татан буулгаж мөн аймгийн Батноров суманд;

17) Хэнтий аймгийн Хэрлэн хороог татан буулгаж мөн аймгийн Дархан суманд;

18) Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан хороог татан буулгаж мөн аймгийн Дэлгэрхаан суманд;

19) Сэлэнгэ аймгийн Ерөө хороог татан буулгаж мөн аймгийн Ерөө суманд.

2. Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хот, Түнхэл хороог Мандал суманд нэгтгэн харьяалуулсантай холбогдуулан Мандал сумын төвийг Зүүнхараад төвлөрүүлсүгэй.

3. Засгийн газарт даалгах нь:

а) энэ тогтоолын I дүгээр зүйлд заасан хот, хороодыг засаг захиргааны хувьд тухайн суманд нь нэгтгэн харьяалуулсантай холбогдуулан тэдгээр сумын иргэдийн Нийтийн Хурлыг шинэчлэн байгуулах, Засаг дарга нарыг томилж ажлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу зохион байгуулсугай;

б) аймаг, сум шинээр байгуулсан болон зарим хот, хороодыг тухайн сумдад нь нэгтгэн харьяалуулсантай холбогдуулан тэдгээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид оршин суугаа иргэдийн хаягийн бүртгэлийг шинэчлэх арга хэмжээ дөч хэрэгжүүлсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан хэвсрэлтэд дурдсан Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, зарлигийн заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Их Хурлын 1994  
оны 36 дугаар тогтоолын хэвсгэл

АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ЗАРЛИГ,  
ЗАРЛИГИЙН ЗААЛТЫН ЖАГСААЛТ

1. «Орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай» 1959 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн 129 дүгээр зарлигийн Сүхбаатар аймгийн Бүрэнцогт, Хэнтий аймгийн Бэрх, Дорнод аймгийн Эрээн хороо гэсэн хэсэг.

2. «Хороо захиргаа байгуулах тухай» 1960 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 44 дүгээр зарлиг.

3. «Зарим аймгийн засаг захиргааны зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай» 1961 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 7 дугаар зарлигийн 4 дүгээр заалт.

4. «Зарим аймгийн засаг захиргааны зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай» 1963 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 2 дугаар зарлигийн 2 дугаар заалт.

5. «Тосонцэнгэл сумын төвийг хот болгох тухай» 1963 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 81 дүгээр зарлиг.

6. «Сэлэнгэ аймагт Түнхэлийн хороо захиргаа байгуулах тухай» 1965 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 9 дүгээр зарлиг.

7. «Улаанбаатар хотод засаг захиргааны районууд байгуулах тухай» 1965 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 79 дүгээр зарлиг.

8. «Налайх хотыг Улаанбаатар хотод харьяалуулах тухай» 1965 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 250 дугаар зарлиг.

9. «Гэчуурт хороо байгуулах тухай» 1968 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 135 дугаар зарлиг.

10. «Зүүнбаян хотын зохион байгуулалтыг өөрчлөх тухай» 1971 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 49 дүгээр зарлиг.

11. «Орон нутгийн засаг захиргааны нэгж байгуулах тухай» 1971 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 55 дугаар зарлиг.

12. «Сум, хорооны төвийн нэрийг батлах тухай» 1972 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 158 дугаар зарлигийн Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Говь-Алтай аймгийн Гуулин, Дорноговь аймгийн Замын-Үүд, Зүүнбаян, Сайншанд, Дорнод

аймгийн Эрээн, Өвөрхангай аймгийн Баантээг, Сэлэнгэ аймгийн Дулаанхаан, Ерөө, Түнхэл, Сүхбаатар аймгийн Бүрэн цогт, Хэнтий аймгийн Бэрх хорооны төвийг баталсан хэсэг.

13. «Хажуу-Улаанд хороо байгуулах тухай» 1973 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 323 дугаар зарлиг.

14. «Хороо байгуулах тухай» 1974 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 2 дугаар зарлиг.

15. «Хэрлэвчлэн-Улааны засаг захиргааны хороо байгуулах тухай» 1974 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 204 дүгээр зарлиг.

16. «Хатгал хороог орон нутгийн хот болгох тухай» 1975 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 73 дугаар зарлиг.

17. «Сум, хороо шинээр байгуулах тухай» 1977 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 64 дүгээр зарлигийн 1-ийн «в» заалт.

18. «Зарим сумыг хороо болгох, татав буулгах тухай» 1978 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 301 дүгээр зарлигийн 2 дугаар заалт.

19. «Багануурын хороог район болгон өөрчлөн байгуулах тухай» 1980 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 43 дугаар зарлиг.

20. «Хороо байгуулах тухай» 1981 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 347 дугаар зарлиг.

21. «Сум, хороо байгуулах тухай» 1982 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 272 дугаар зарлигийн 2 дугаар заалт.

22. «Хороо байгуулах тухай» 1983 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 208 дугаар зарлиг.

23. «Хороо байгуулах тухай» 1988 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 24 дүгээр зарлиг.

24. «Хороо байгуулах тухай» 1989 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 125 дугаар зарлиг.

25. «Хороо байгуулах тухай» 1989 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 126 дугаар зарлиг.

26. «Зарлигийн заалтад өөрчлөлт оруулах тухай» 1990 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 170 дугаар зарлиг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИВЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1994 оны 4 дүгээр

Дугаар 31

Улаанбаатар

сарны 21-ний өдөр

хот

ШАШНЫ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ЗӨВЛӨЛИЙГ  
ШИНЭЧЛЭЙ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Нэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн зохиулагч:

Г. Лхагвасүрэн — Ерөнхийлөгчийн Тамгын газрын шашны асуудал эрхэлсэн түшмэл, дэд доктор

Гишүүд:

Н. Энхбаяр — Монгол Улсын Соёлын сайд

Д. Сугар — Монгол Улсын Хууль зүйн дэд сайд

Ж. Чойнхор — Монгол Улсын Гадаад харилцааны дэд сайд

Ш. Бира — ОУМСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, академич

Ц. Цэндий — ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэнгийн захирал, доктор

Х. Шамбуу — МУУИС-ийн багш, доктор

Л. Тэрбиш — МУУИС-ийн багш

Л. Хүрэлбаатар — ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэнгийн секторын эрхлэгч, доктор

- С. Цэдэндамба — УИХ-ын дэргэдэх судалгааны төвийн ажилтан
- Д. Цэрэнсодном — ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, доктор
- Д. Чимэдрэгзэн — Өндөр настан
- Г. Чулууибаатар — УИХ-ын дэргэдэх судалгааны төвийн ажилтан, дэд доктор

Хоёр, Ерөнхийлөгчийн дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Гурав, Энэ зарлиг гарсантай холбогдуулан «Шашны асуудал эрхлэх зөвлөл байгуулах тухай» БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1991 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 60 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 51 дүгээр зарлигийн хавсралт

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ДЭРГЭДЭХ ШАШНЫ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөл (энэ дүрэмд цаашид «зөвлөл» гэх) нь төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааны төлөөр Монгол Улсын хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Монгол Улсын Ерөнхийлөгчид мэргэжлийн үүднээс зөвлөн туслалх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлдөх байгууллага мөн.

2. Зөвлөл нь төрийн захиргааны холбогдох зарим төв байгууллагын удирдах албан тушаалтан, шашин судлал, мэдлэг ухаан, соёлын түүхийн асуудлаар мэргэшсэн нэр хүнд

тэй эрдэмтэн мэргэжилтнүүд хийгээд шашны уламжлалыг сайтар мэдэх ахмад сэхээтэн, өндөр настнаас бүрдэнэ.

3. Зөвлөл үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, төр, сүм хийдийн харилцааны тухай хууль тогтоомж болон энэ дүрмийг удирдлага болгоно.

4. Зөвлөл нь дор дурдсан үндсэн чиг хүрээний асуудлуудыг хэлэлцэж санал дүгнэлт гаргана:

— төр, сүм хийдийн харилцааг зохицуулах, төрөөс шашны, сүм хийдийн талаар баримтлах бодлогыг боловсруулах, тодруулан нарийвчлах, хэрэгжүүлэх чиглэлүүдээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн баримтлах байр суурь, хэрэгжүүлэх арга хэмжээ;

— шашны хоорондын харилцааг зохицуулах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга зам, хэрэгслийн талаархи Ерөнхийлөгчийн байр суурь, үйл ажиллагааны асуудал;

— иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэх, лам сангаартан нарын иргэний эрх, үүргийг хүний эрхийн түгээмэл зарчмуудад нийцүүлэн боловсронгуй болгох, хэрэгжүүлэх асуудал;

— төр, сүм хийдийн харилцааг зохицуулах тухай тус улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн баримтлах байр суурь, санал санаачилга;

— шашны хүмүүнлэг, энэрэнгүйн уламжлалыг төлөвшүүлэх, мэдлэг ухааны төрөл бүрийн салбараар шашны хүрээнд хуримтлагдсан өв, зан заншлын дэвшилтэт уламжлалыг бүтээлчээр эзэмшин хөгжүүлэх чиглэлээр төрөөс явуулах үйл ажиллагаа;

— Монгол соёл иргэншлийн салбарт Ерөнхийлөгчийн баримтлах бодлого, үйл ажиллагааны тухай санал зөвлөмж өгөх туслах;

— Ерөнхийлөгчийн шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

5. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан байна.

6. Зөвлөлийн хуралдаанд гишүүдийн олонхи нь оролцсон бол түүнийг хүчинтэй гэж үзнэ.

7. Зөвлөлийн хуралдаан нь хуулийг дээдтэн, асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэн, олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд тулгуурлана.

8. Шаардлагатай бол зөвлөлийн хуралдааныг холбогдох байгууллагын төлөөлөгчдийг оролцуулан өргөтгөсөн бүрэлдэхүүнтэйгээр хийж болно.

9. Тодорхой асуудлаар гадны байгууллагын эрдэмтэн, мэргэжилтнүүдээр экспертиз хийлгэсэн дүнг зөвлөлийн хуралдаанаар сонсож болно.

10. Зөвлөлийн хуралдааныг өргөтгөж хийсэн үед хуралданд оролцогчдын санаа бодол, үндэслэлтэй танилцсаны дараа гишүүдийн одоохийн саналаар зөвлөлийн хуралдланыг хаалттай хэлбэрээр үргэлжлүүлж болно.

11. Зөвлөлийн хуралдаанаас дүгнэлт, зөвлөмж гаргана.

12. Зөвлөлийн хуралдааны дүгнэлт, зөвлөмжийг зөвлөлийн зохицуулагч Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулна.

13. Зөвлөл нь ажлаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн өмнө харууцна.

14. Зөвлөлийн гишүүд шашины-сүм хийдийн ажил амьдралтай биечлэн танилцах, лам хувраг, сүсэгтэн олны санга бодлыг сонсож, холбогдох арга хэмжээ авахыг зохиох байгууллага, албан тушаалтанд зөвлөх, төрөөс шашины, сүм хийдийн талаар баримталж байгаа бодлогыг тайлбарлан сурталчлах, төр, сүм хийдийн харилцааны тухай хууль тогтоомж биедүүлэхийг шаардах үүрэгтэй.

15. Зөвлөл нь аймаг, нийслэлийн Засаг дарга нарын дэргэд орон тооны бус салбар зөвлөлтэй байна. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга байна.

16. Зөвлөлөөс төр, сүм хийдийн харилцааны зөвчилж чадах асуудлуудаар оюул-арга зүйн хурал, хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулж, эрдэм шинжилгээний болон бусад байгууллаагад тодорхой асуудлаар судалгаа хийх, төсөл боловсруулах захиалга өгч хийлгэж болно.

17. Зөвлөлийн гишүүд боловсруулж буй асуудалд холбогдох мэдээ, тоо баримтыг зохиох байгууллаагаас гаргуулан авч танилцах эрхтэй. Төрийн болон шашины холбогдох байгууллагууд зөвлөлийг шаардлагатай мэдээллээр тогтоосон хугацаанд нь хангах үүрэгтэй.

18. Шаардлагатай асуудлаар зөвлөлийн гишүүдээс болон үндсэн байгууллаагатай нь тохиролцсоны үндсэн дээр бусад байгууллаагын эрдэмтэн, мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

19. Зөвлөлийн болон ажлын хэсгийн үйл ажиллагааг Зөвлөлийн зохицуулагч зохион байгуулна. Зохицуулагч нь Ерөн-

хийлөгчийн Тамгын газрын шашины асуудал эрхэлсэн түшмэл байна.

20. Зөвлөлийн гишүүдийг Ерөнхийлөгчийн зарлигаар толимж, чөлөөлнө. Зөвлөлийн гишүүд Монгол Улсын Ерөнхийлөгчийн гарын үсэг, тамга бүхий үнэмлэхтэй байна.

21. Зөвлөлийн бичиг хэрэг, техник үйлчилгээний асуудлыг Ерөнхийлөгчийн тамгын газар хариуцна.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 4 дүгээр

Дугаар 52

Улаанбаатар

сарын 21-ний өдөр

дэг

### ШАШНЫ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТҮШМЭЛИЙН ОРОН ТОО БНИ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт шашины асуудал эрхэлсэн түшмэлийн орон тоо бни болгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИВАЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1994 оны 5 дугаар  
сарны 9-ний өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

ЗАРИМ ХҮНИЙГ МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Галын аюулаас хүний амь, улс, иргэдийн үлэмж хэмжээний өмч хөрөнгийг авран хамгаалахад мэргэжлийн өндөр ур чадвар, эр зориг, авхаалж самбаа гарган ажилласныг үнэлж дор дурдсан хүмүүсийг медалнудаар шагнасугай.

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР

1. Чойжинсамбуугийн — Нийслэлийн гал түймэртэй  
Ганхуяг тэмцэх хэлтсийн байцаагч
2. Лувсандамбын — мөн хэлтсийн 14 дүгээр гал  
Гомбосүрэн унтраах ангийн гал сөнөөгч

«ШУДАРГА ЖУРАМ» МЕДАЛИАР

- Пүрэвнуцагийн Ууганбаяр — Нийслэлийн гал түймэртэй  
тэмцэх хэлтсийн 10 дугаар  
гал унтраах ангийн гал  
сөнөөгч



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

1994 оны 3 дугаар

сарын 9-ний өдөр

Дугаар 52

Улаанбаатар

хот

**ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХӨГЖЛИЙН  
ИНСТИТУТИЙН ОРОН ТОО, БҮТЦИЙГ ТОГТООХ,  
ДҮРЭМ, ТӨСВӨӨС ОЛГОХ САНХҮҮЖИЛТИЙН  
ХЭМЖЭЭ, САРЫН ЦАЛИНГИЙН САНГ БАТЛАХ  
ТУХАЛ**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийн удирдлагын орон тоог захирал 1, дэд захирал 2, аппаратын орон тоог 85 (нормативаар ажиллах үйлчилгээний ажилчдыг оролцуулахгүйгээр) хүртэй байхаар, бүтцийг Төрийн удирдлагын тэнхим, Менежментийн тэнхим, Эдийн засгийн тэнхим, Эрх зүйн тэнхим, Гадаад хэлний тэнхим, Компьютерийн тэнхим, Төрийн бодлого судлах төв, Зөвлөлтөө өгөх төв, Санхүү, аж ахуй, үйлчилгээний хэлтэс, Номын сан, Техникийн тасагтай байхаар тус тус тогтоосугай.

2. Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийн дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

3. Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийн 1994 оны зардалд зориулан төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээг 66000,0 мянган төгрөгөөр, мөн онд мөрдөх цалингийн санг 7 дугаар сарын 01 хүртэл хугацаанд 1486,0 мянган төгрөгөөр, 7 дугаар сарын 01-нээс хойшхи хугацаанд 1940,0 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын шадар сайд

П. ЖАСРАЙ

А. ЭНЭБИШ

## ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДААГЫН ХӨГЖЛИЙН ИНСТИТУТИЙН ДҮРЭМ

### Нэг. Иийтлэг үндэслэл

1. Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт (цаашид институт гэх) Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, холбогдох бусад байгууллагын захиалгаар төрийн албаны болон аж ахуйн ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшлүүлэх, түүнчлэн төрийн бодлого, удирдлагын нэн чухал асуудлаар эрдэм шинжилгээ, шуурхай судалгааны ажил эрхлэх үндсэн үүрэг бүхий Засгийн газрын сургаат эрдэм шинжилгээний байгууллага мөн.

2. Институтийн зорилго нь удирдлагын үндэсний чадавхийг дээшлүүлэх, төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах талаар төр, засгийн удирдах дээд байгууллагад туслалахад оршино.

3. Институт нь Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, энэ дүрмийг мөрдөж ажиллана.

4. Институтийн үйл ажиллагааг Засгийн газрын сургаат, судалгаа, шинжилгээний байгууллаагынх нь хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар зохицуулна.

5. Институтийн захирлыг Засгийн газар, дэд захирлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай зөвшилцсөний үндсэн дээр захирал томилно.

6. Захирал институтийн ажлыг удирдаж, үйл ажиллагаатай нь холбогдсон асуудлаар Монгол улсын хууль тогтоомжийн актад ийнхүүдэн тушаал гаргаж, түүний биелэлтийг хангуулна.

7. Институт тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Институт билэгдлийн ялгах тэмдэг (эмблема)-тэй байж болно.

8. Институт нь захиргааны зөвлөлтэй байх бөгөөд түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирал батална.

9. Институт нь эрдмийн зөвлөлтэй байна. Институтийн захирал нь эрдмийн зөвлөлийг удирдаж, зөвлөлийн бүрэлдэхүүн, эрдэмтэн нарийн бичгийн даргыг томилно.

10. Институт нь дараахь журмаар санхүүжигдэнэ:

а) төрийн албаны ажилтан бэлтгэх, дэвтэн сургах мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшлүүлэх, түүнчлэн төрийн хийгээд төрийн захиргааны байгууллагын захиалгаар төсвийн дагуу судалгаа шинжилгээний ажил хийхтэй холбогдсон зардлыг зохих журмын дагуу төсвөөс санхүүжүүлж, үр дүнд нь Засгийн газар хяналт тавина;

б) гэрээ, захиалгаар аж ахуйн ажилтан сургах, эрдэм шинжилгээ, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, зөвлөлгөө өгөх зэрэг төлбөргүй үйлчилгээ болон бусад дүйл ажиллагаанаас төсвийн гадуурхи хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлдэг зардлын зарим хэсгийг санхүүжүүлнэ.

11. Институтийн бүтэц, удирдлагын болон аннاراتын оронгоо, төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээ, сарын цалингийн саяг Засгийн газар батална.

### Хоёр. Институтийн үүрэг, эрх

12. Институт дор дурдсан үүрэг хүлээнэ:

а) төрийн албаны болон аж ахуйн ажилтны сургалтыг өндөр хөгжилтэй гадаад орны жишигт хүргэх арга хэмжээ авах;

б) төрийн албаны болон аж ахуйн өндөр мэргэшлийн ажилтан бэлтгэх шаардлагад нийцүүлэн сургалтын төлөвлөгөө хичээлийн агуулга, хөтөлбөрийг байнга боловсронгуй болгох;

в) төрийн албаны болон аж ахуйн ажилтныг 1,5—2 жилийн хугацаатай магистрын болон нэг жилийн хугацаатай үндсэн ангийн сургалтаар бэлтгэх, 3—6 сарын хугацаатай сургалтаар дахин мэргэшлүүлэх, богино хугацааны сургалтаар мэргэшлийг нь дээшлүүлэх, тодорхой чиглэлийн төрөлжсөн сургалтаар дэвтэн сургах;

г) Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, холбогдох бусад байгууллагын захиалгаар эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, төсөд боловруулах, зөвлөлгөө өгөх;

д) өөрийн орны хийгээд гадаад улсын сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай зохих журмын дагуу хамтран ажиллах, энэ зорилгоор багш, эрдэмтдийн хамтдаг ажиллуулах, эрдэм шинжилгээний хурал, семинар зохион

байгуулах, харилцан тохиролцсон нөхцөлөөр багш, эрдэм шинжилгээний ажилтан, сонсогчид харилцан солилцох;

е) магистрын зэрэг, диплом олгох сургалтыг дүүргэж байгаа сонсогчдын дипломын ажил, магистрын зэрэг горилсон бүтээлийг төрийн болон аж ахуйн байгууллагын захяалгаар хийлгэж, үр дүнг нь үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд тусалцаа үзүүлэх;

ж) гадаад оронд бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх, дахин мэргэшлүүлэх төрийн болон аж ахуйн ажилтны бэлтгэл хангахад зориулсан сургалт явуулах;

з) багш, эрдэм шинжилгээний ажилтныг сонгон шалгаруулах, шийшиж ажиллуулахын хамт тэднийг магистрантур, аспирантур, докторантурт суралцуулах, гадаад сургалтад хамруулах, гадаад, дотоодын өндөр мэргэжлийн хүмүүсийг дагалдуулан сургаж ажиллуулах, үйлдвэрлэл дээр дадлагыг хийлгэх зэргээр чиглэсэн зорилготойгоор мэргэшлийг нь дээшлүүлж чадваржуулах;

и) төрийн болон аж ахуйн байгууллагатай харилцан мэдээлэл солилцох замаар институт, төгсөгчдийн хооронд эргэх холбоо тогтоож үйл ажиллагаанд нь дүгнэлт хийсний үндсэн дээр сургалтын чанарын түвшинг дээшлүүлэх арга хэмжээ авах;

к) судалгаа, шинжилгээний ажил явуулахдаа түүнтэй холбогдсон мэдээллийн нууцыг зохих журмын дагуу хадгалах.

### 13. Институт дор дурдсан эрх эдэлнэ:

а) төрийн албаны болон аж ахуйн ажилтны сургалтын хэрэгцээ, судалгаа, шинжилгээний ажлын чиглэлийг улс орны хөгжлийн шаардлагад нийцүүлэн боловсруулж төрийн бодлогод тусгуулах талаар санал, зөвлөмж гаргах;

б) төрийн албаны болон сургалт, эрдэм шинжилгээ, аж ахуйн байгууллагын удирдах ажилтан, эрдэмтэд, мэргэжилтнийг зохих журмаар тохиролцон сургалтын ажилд оролцуулах;

в) сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, зөвлөлгөө өгөхөд шаардлагатай мэдээ, тоо баримтыг холбогдох байгууллагаас зохих журмын дагуу авч хэрэглэх;

г) сургаж бэлтгэсэн ажилтныг тэдний мэргэшлийн түвшинд нь тохирсон албан тушаалд ажиллуулах, эсхүл тэднийг зохих шатны сургалтад хамруулах саналыг холбогдох байгууллагад гаргах;

д) эрдэм шинжилгээний бүтээл, сурах бичиг, сэтгүүл, гарын авлагыг хэвлүүлэх, нийтийн хүртээл болгох;

е) гадаад орныг ажил төрлийн институт, олон улсын байгууллагатай зохих журмын дагуу ажил хэргийн холбоо тогтоож, гэрээ байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;

ж) сургалтын хэрэгцээ шаардлагыг харгалзан холбогдох байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр институтийн салбарыг орон нутагт байгуулан ажиллуулж, үйл ажиллагааг нь мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах;

з) хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан багш, эрдэм шинжилгээний ажилтан, ажилчныг Хэрэг эрхлэх газартай тохиролцож төрийн дээд шагналд тодорхойлох;

и) институтийн дичээлийн жилийн үргэлжлэх хугацаа, төрийн албаны болон аж ахуйн ажилтан бэлтгэх, дэнтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх сургалтын хугацааг холбогдох эрх бүхий байгууллагатай тохиролцон тогтоох;

к) байгууллагын нэгж, хэсгийн үйл ажиллагааны дэг журмыг тогтоож мөрдүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

1994 оны 3 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 55

Угсаа  
хот

ОРОН СУУЦНЫ САЛБАРЫГ ЗАХ ЗЭЭЛИЙН  
ХАРИЛЦААНД ШИЛЖҮҮЛЭХ БЭЛТГЭЛИЙГ  
ХАНГАХТАЙ ХОЛБОГДСОН ЗАРИМ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын Өмч хувьчлалын комиссоос холбогдох нам, газартай хамтран боловруулсан «Орон сууцны салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх талаар 1994—1996 онд хийх ажлын хөтөлбөр»-ийг зөвшөөрч, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, биелэлтэд нь хиналт тавих үүргийг Засгийн газрын Өмч хувьчлалын комисст хариуцуулсугай.

Үүнтэй холбогдуудан тус комиссын орон тоог 3-аар, 1994 онд мөрдөх сарын цэвэрлэлийн санг энэ оны 7 дугаар сарын 01 хүртэл хугацаанд 33,0 мянга, 7 дугаар сарын 01-нээс хойшхи хугацаанд 46,0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсүгэй.

2. Орон сууцны салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэхэд шаардлагатай энэ тогтоолын хавералтад заасан хууль тогтоомж, дүрэм, журмыг хугацаанд нь боловруулахыг Засгийн газрын Өмч хувьчлалын комисс (Л. ЭНЭБИШ), Дэд бүтцийн хөгжлийн нам (Р. САНДАЛХАН), Хууль зүйн нам (Н. ЛУВСАНЖАВ), Сангийн нам (Д. ДАВААСАМБУУ), Нийслэлийн Засаг дарга (Ц. БААСАНЖАВ)-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н. ЖАСРАЙ

Монгол Улсын шадар сайд

Л. ЭНЭБИШ

Засгийн газрын 1994 оны 55 дугаар  
тогтоомжид зааснаар

ОРОН СУУЦНЫ САЛБАРЫГ ЗАХ ЗЭЭЛИЙН  
ХАРИЛЦААНД ШИЛЖҮҮЛЭХЭД ШААРДААГАТАЙ  
1994 ОНД БОЛОВСРУУЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖ,  
ДҮРЭМ, ЖУРМЫН ЖАГСААЛТ

№	Боловсруулах хууль тогтоомж, дүрэм, журмын нэр	Төсвийг бо- ловсруулах дуусах ху- гцдаа (сар- рээр)	Харшуган боловсруулах нам, газрын нэр
1.	Орон сууцны бодлогын үндсийн тухай Монгол Улсын хууль	VI—VII	Засгийн газрын Өмч хувьчлалын комисс, Дэд бүтцийн хөгжлийн нам, Хууль зүйн нам, Сангийн нам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
2.	Орон сууцны хантрааг өмчлөх (хоршоолол), хэ- сэгчлэл өмчлөх (кондо- минум) хэлбэрүүдийн тухай хууль, эрхийн акт	VI	Засгийн газрын Өмч хувьчлалын комисс, Дэд бүтцийн хөгжлийн нам, Хууль зүйн нам
3.	Орон сууцны барилда- лах тухай хууль, эрхийн акт	VII	Хууль зүйн нам, Нийслэлийн За- сэг даргын Тамгын газар (Мон- голбичетай хантарч)
4.	Орон сууцны ашиглаа- лын дүрэм	V	Дэд бүтцийн хөгжлийн нам, Хууль зүйн нам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
5.	Орон сууц хувьчлах дүрэм	IV	Засгийн газрын Өмч хувьчлалын комисс, Хууль зүйн нам, Ний- слэлийн Засаг даргын Тамгын газар
6.	Хувьчлах орон сууцныг үлэхэд журам	IV	Засгийн газрын Өмч хувьчлалын комисс, Дэд бүтцийн хөгжлийн нам
7.	Орон сууцны сан бай- гуулах зарцуулах журам	IV—V	Засгийн газрын Өмч хувьчлалын комисс, Сангийн нам, Дэд бүтцийн хөгжлийн нам

Засгийн газрын 1994 оны 55 дугаар  
тогтоолээр авчсөөрөө.

**ОРОН СУУЦНЫ САЛБАРЫГ ЗАХ ЗЭЭЛИЙН  
ХАРИЛЦААНД ШИЖҮҮЛЭХ ТАЛААР 1994—1996  
ОНД ХИЙХ АЖЛЫН ХӨТӨЛБӨР**

Энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилго нь зах зээлийн зарчимд тулгуурласан орон сууцны салбарыг бий болгох үндсийг бүрдүүлэхэд оршино. Энэ хөтөлбөрийг газар өмчлөл, орон сууцны ашиглалт, хот байгуулалт зэрэг орон сууцтай шууд холбогдох бүхий салбар болон улс орны эдийн засгийн салбарт хийгдэх нийтлэг шинэчлэлүүдтэй уялдуулан хэрэгжүүнэ.

Орон сууцны салбарт 1994—1996 онд хийх шинэчлэл нь дараахь тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Үүнд:

1. Орон сууц, нийгмийн аж ахуйн үйлчилгээний үнэ, тари-  
фыг зах зээлийн нийтлэг зарчимд нийцүүлэх, шинэчлэх.

2. Орон сууцны салбарын удирдлага, зохион байгуулалтыг  
зах зээлийн нөхцөлд тохируулан өөрчлөх.

3. Орон сууцны засвар, үйлчилгээний ажлыг эрхлэх бай-  
гууллага, аж ахуйн нэгжүүдийг олончтой хувилбараар хувьч-  
лах, шинээр бий болгох үндсэн дээр өрсөлдөх нөхцөлийг  
бүрдүүлэх.

4. Зах зээлийн харилцаа төлөвшилийн хэрээр орон сууц-  
ны салбар дахь өмчийн харилцааг шинэчилж, төрийн өмчид  
үлдэх орон сууцнаас бусдыг аль болох хувийн секторт шил-  
жүүлэх, хувьчлах.

5. Орон сууцанд оршин сууж буй бага орлоготой айл өрх,  
тахир дутуу, өндөр илстэй хүмүүс зэрэг хүн амын эхлэн хэс-  
гийн нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлэх.

6. Орон сууцны барилгыг барих, санхүүжүүлэх ажлыг  
шинэ журамд шилжүүлэх, үүнтэй уялдуулан орон сууц барих  
ажилд өрсөлдөх, төсвийн бус дөрвөлгийн эх үүсвэр ашиглах  
нөхцөл бүрдүүлэх.

7. Орон сууцны салбарт мөрдөж буй хууль тогтоомж, дү-  
рэм, журам, норм нормативыг шинэчлэх, орон сууцыг өмч-  
лөх, зөвлөх, түрээслэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх.

8. Орон сууцны салбарын хүрээнд харилцагч бүх талуудыг  
тухайлбал, орон сууцны ашиглалт, засвар үйлчилгээ,  
барих ажлыг эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад ажиллааг-  
чид, оршин суугчид, өмчлөгчдийн сургалтыг зохион байгуулах.



**Нэг. Орон сууцны талбай, үйлчилгээний үнэ, тарифыг зах зээлийн нийтлэг зарчимд нийцүүлэн шинэчлэх талаар**

Орон сууцны талбай, засвар үйлчилгээний үнийг орон сууцны засвар үйлчилгээ, удирдлага, эзэгдэл хорогдлын зэрэг бүх зардлыг багтаасан, орон сууцны хэвийн үйл ажиллагааг хангаж чадахуйц түвшинд тогтооход чиглүүлж өөрчилнө.

Хамгийн анхны алхам болгож орон сууц, нийтийн аж ахуйн үнэ, тарифыг чөлөөт тогтолцоонд шилжүүлнэ. Ингэхдээ 1994 онд эдгээр үнэ, тарифын өөрчлөлтийн үндэслэлийг Засгийн газраас хянаж зөмнүүлнэ. Цаашдаа сууц, нийтийн аж ахуйн үнэ, тарифыг нэгдсэн байдлаар тогтоохоос татгалдаж, зөвхөн өмчлөгч (төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд), оршин суугчдын хоорондын хэлцлийн үндсэн дээр тогтоодог зарчимд үндсэндээ шилжинэ.

Төрийн өмчид байгаа орон сууцны үнэ, тарифыг хөлсний гэрээгээр сууж буй (нэг хүнд ногдох орон сууцны талбайн хэмжээ нь нийгмийн тогтоогдсон нормоор хязгаарлагдсан) оршин суугчдын хувьд орон нутгийн засаг захиргааны байгууллагын хяналтад нийгмийн бодлогын хэсэг болгон хадгалах бөгөөд түрээсийн гэрээний үндсэн дээр (нэг хүнд ногдох орон сууцны талбайн хэмжээ нь аль нэг байдлаар хязгаарлагдахгүй) оршин суугчдын хувьд зах зээлийн чөлөөт үнэд бүрэн шилжинэ.

Төрийн өмчид байгаа орон сууцны төлбөрийн тогтолцоог нэг загвараас гаргаж гухайн орон сууцны загвар, байршил, тохилго байдал, засвар, үйлчилгээний чанараас хамааруулсан шалгууртай үнэ, тарифын сүлжээг бий болгож мөрдүүлнэ.

Үүнтэй уялдуулан төрийн өмчийн орон сууцны санг хөлсний боловч түрээсийн гэрээгээр ашиглуулах гэж хувааж ашиглах бөгөөд нэг хүнд ногдох орон сууцны талбайн нийгмийн нормыг орон сууцны хангамж, эрүүл ахуйн шаардлагыг харгалзан тогтооно. Энэ ажлыг аймаг, хотын засаг захиргааны байгууллагууд өөрсдийн орон нутгийн онцлогийг харгалзан хийх бөгөөд Засгийн газрын зүгээс нэгдсэн арга зүйн удирдлагаар хангаж, нэг хүнд ногдох орон сууцны талбайн доод хэмжээг тогтоож, хяналт тавина.

Орон сууц өмчлөгчид нь засвар, үйлчилгээний зардлаа өөрсдөө (орон сууцны байшинг хамтран өмчлөсөн тохиолдолд эзэмшэж буй талбайтай харьцангуйгаар) хариуцна.

### Хоёр. Орон сууцны салбарын удирдлага, зохион байгуулалтын шинэчлэлийн талаар

Энэ хүрээнд хийгдэх шинэчлэл нь орон сууцны салбарт өмчлөгч, ашиглалт, мэргэжлийн удирдлагыг салган, тэдний эрх, үүргийг зааглах, харилцан хяналт тавих нөхцөл бий болгоход чиглэнэ.

Орон сууцыг өмчлөгч байгууллага, орон сууцны ашиглалт, хяналт, засвар, үйлчилгээний ажил гүйцэтгэгч байгууллагуудын үүргийг салгана.

Орон сууцны салбарт төрийн байгууллага нь:

1. Төрийн өмчийн орон сууцыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулна.

2. Орон сууцны ашиглалт, засвар, үйлчилгээний стандарт, норм, нөхцөлийг тогтоож, холбогдох дүрэм, зааврыг гаргаж, тэдгээрийг өмчийн бүх хэлбэрт мөрдүүлж, биелэлтэд нь хяналт тавина.

3. Орон сууцны ашиглалт, засвар, үйлчилгээ хийх байгууллагуудыг өрсөлдүүлэх үндсэн дээр сонгож аван гэрээ байгуулж, төрийн өмчийн орон сууцны засвар, үйлчилгээг хийлгэж, түүний чанарт өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.

4. Төрийн өмчийн орон сууцанд оршин суугчидтай гэрээ хийж, (хөлслөх болон түрээслэх) өмчлөгчийн хяналтыг хэрэгжүүлнэ.

5. Орон сууцны хороолол, барилга барих газар, түүвтэй холбогдсон дэд бүтцийн асуудлыг судалж шийдвэрлэнэ.

Үүний дэрэгцээгээр орон сууцны ашиглалт, хяналтын албыг аймаг, нийслэлийн Засаг дарга, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дэргэд бий болгоно.

Орон сууц хувьчилж эхлэхтэй уялдуулан орон сууц үл хөдлөх хөрөнгийн эрх зээлийг бий болгох, орон сууцны диатгалын тогтолцоог төлөвшүүлэх, орон сууц, үл хөдлөх хөрөнгийг барьцаалах хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэх арга хэмжээг дэс дараатайгаар авч хэрэгжүүлнэ.

Орон сууцаа хувьчилж авсан орон сууц өмчлөгчдийн хамтран өмчлөх (хоршоолол), хэсэгчлэн өмчлөх (кондоминиум) хэлбэрүүдийг бий болгож төлөвшүүлнэ.

### Гурав. Орон сууцны ашиглалт, засвар үйлчилгээний ажлыг эрхлэх байгууллагуудыг өөрчлөн байгуулах талаар

Орон сууцны ашиглалт, засвар, үйлчилгээг чөлөөтэй, өр-

сөлдөөний үндсэн дээр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэхэд шинэтгэл чиглэгдэнэ.

Одоо байгаа орон сууц ашиглалтын конторуудыг аж ахуйн хувьд бүрэн бие даалгана.

Төрийн байгууллагын зүгээс орон сууцны ашиглалт, засвар, үйлчилгээний ажлын стандарт, норм, нөхцөлийг гаргаж мөрдүүлэх бөгөөд үүний биелэлтийг төрийн байгууллага болон оршин суугчдын зүгээс хянах тогтолцоог бий болгоно.

Орон сууцны ашиглалт, засвар, үйлчилгээний байгууллагуудыг оновчтой хэлбэрээр хувьчлах ажлыг аймаг, нийслэл, хотын өмч хувьчлалын комиссууд хэрэгжүүлэхийн зэрэгцээ энэ салбарт хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд бий болох явдлыг бүх талаар нь дэмжинэ.

Ийм төрлийн ажил эрхлэх аж ахуйн байгууллагуудын тоо олшрох хэрээр ажил, үйлчилгээний чанарт тавих стандарт, шаардлагыг өндөржүүлж, тэдний дунд тендер зарлан сонгон шалгаруулж, гэрээ байгуулах замаар өрсөлдөөнийг бий болгоно.

Орон сууцны ашиглалт, засвар, үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжүүд нь тодорхой хугацаагаар (1—2 жилээр) өмчлөгчид (төрийн байгууллага, орон сууцны хоршоолол, кондоминум)-тэй гэрээ байгуулж, биелэлтийг нь дүгнэж, сунгах үзэхээ шийдвэрлэдэг журамд шилжинэ.

Орон сууцны засвар, үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжүүдийг ерөнхий менежментийн болон тусгайлан чиглэлийн хэмээн төрөлжүүлнэ.

Орон сууцны ийтийн эзэмшлийн аж ахуйн засвар, үйлчилгээг мэргэжлийн болон үйлчилгээний байгууллагаар төлбөртэйгээр хийлгэж, зардлыг өмчлөгчид бүрэн харууцна. Төрийн болон хувийн өмчийн орон сууц бүхий байшингийн засвар, үйлчилгээг хийлгэх үйлчлэгч байгууллагыг сонгож гэрээ байгуулах, биелэлтийг хянаж төлбөр тооцоо хийх ажлыг хөрөнгийн дийлэнх хэсгийг өмчлөгч тал нь харууцна.

### **Дорно, Орон сууцны салбарын өмчийн харилцааг шинэчлэх, хувьчлах талаар**

Орон сууцны салбарт хувийн өмчийн хэвшилийг бий болгож, зах зээлийн харилцаанд шилжихийн хэрээр орон сууцныг гэд болох их хэмжээгээр хувьчлах нөхцөлийг бүрдүүлэхэд шинэтгэл чиглэгдэнэ.

Орон сууцны хувьчлал нь дараахь хэлбэрүүдээр явагдана. Үүнд:

— одоо хөлөний гэрээгээр оршин сууж байгаа оршин суугчид зохих дүрэм, журмын дагуу орон сууцнад хувьчлан авах;

— шинээр ашиглалтад орж буй орон сууцны тодорхой хэсгийг төрийн байгууллагын мэдэлд үлдээн төсвийн байгууллагын ажиллагчид болон өндөр настан, тахир дутуу хүмүүс зэрэг хүн амын эмлэг хэсгийн хэрэгцээг хангахад зориулах бөгөөд үлдсэн хэсгийг байгууллага, аж ахуйн нэгж, хувийн компани, иргэдэд дуудлагын худалдаагаар худалдана;

— аймаг, нийслэл, хотын төрийн байгууллагын мэдэлд бусад өмчлөгчдөөс хууль зүйн дагуу шилжиж ирсэн орон сууцныг нийтэд худалдах;

— орон сууцны дуусаагүй бариагуудыг чиглэлийг нь хадгалах нөхцөлтэйгээр дуудлагын худалдаанд оруулах;

Эдгээр хэлбэрүүдийг хэрэгжүүлэх дүрэм, журмыг Монгол Улсын Өмч хувьчлах тухай хуулийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 1994 оны эхний хагас жилд багтаан гаргана.

Гадаадын болон харьяалалгүй иргэдэд орон сууц хувьчлан өмчлүүлэхгүй.

Өмчлөгч нь орон сууцаа эзэмших, ашиглах, захиран зарцуулахдаа бусдын эрх ашгийг хохироохгүй байх нөхцөлийг бүрдүүлж, үүнтэй холбогдсон дүрэм, эрхийн актыг гаргаж мөрдүүлнэ.

Одоо ашиглагдаж байгаа орон сууцныг хувьчлахдаа оршин суугчдын саналыг харгалзах бөгөөд тодорхой зарчмаар үнэлж худалдана.

Орон сууц хувьчлахад дараахь хөнгөлөлт үзүүлнэ:

— байр хөлслөн авсан өрхийн гишүүн бүрт 5 хэвтгэй дөрвөлжин метр талбайг үнэгүй хувьчилна;

— партизан, хоёр дайнд оролцож тахир дутуу болсон хүмүүст түүний хөлслөн сууж байгаа сууцныг нь үнэгүй хувьчлан олгоно;

— орон сууц хувьчлах үед сууж байгаа сууцныхаа үнийг бэлэн мөнгөөр (хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн дгалан тасалбар оролцуулан) нэг удаа бүрэн төлөх тохиолдолд төлөх бэлэн мөнгөний хэмжээг бууруулж хөнгөлөлт үзүүлнэ;

— амьжиргааны баталгаажих доод түвшингээс бага орлоготой айл, өрхийн орон сууцныг тэдний саналаар хувьчлахгүйгээр төрийн өмчид үлдээж, орон сууцны нийгмийн хамгааллын тогтолцоонд хамааруулна.

Хувьчлагдсан орон сууцны төлбөрт бэлэн мөнгө, хоронго оруулалтын эрхийн бичгийн ягаан тасалбар (нэрлэсэн үнээр нь) хөнгөлөлттэй зээлийг хэрэглэнэ.

Хувьчлагдах орон сууцны нэг хааттай дөрвөлжин метр ашигтай талбайн үнэ болон хувьчлагдсан орон сууцны төлбөрт авах хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн ягаан тасалбарын хэмжээг Засгийн газар тогтооно.

Орон сууцны хувьчлалаас орох орлогыг тусад нь орон сууцны санд төвлөрүүлж хуримтлуулна.

Орон сууцны сан нь Улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг бийж түүнийг цаашид зөвхөн орон сууц, түүний дагалдах барилга, байгууламжийг барих, түүнд олгох зээлийн эх үүсвэрт ашиглана.

Дараахь орон сууцыг хувьчлалд хамааруулахгүй:

- төр, засгийн мэдлийн тусгай үйлчилгээний орон сууц;
- оюутан, сурагчдын дотуур байр;
- цэргийн анги, байгууллагын элэмшлийн орон сууц;
- орон нутгийн тусгай зориулалтын орон сууц (багш, эмч нарын гэх мэт).

Хамтарсан үйлдвэр, олон нийтийн байгууллага, хоршооллын болон хувьчлагдсан байгууллага нь мэдлийн орон сууцлаа хувьчлах асуудлыг өөрсдөө шийдэж, энэ талаар гарсан эрхийн актуудыг мөрдөнө.

### Тал. Орон сууцны салбарт нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлэх талаар

Орон сууцны салбарт үйлчлэх нийгмийн хамгааллын тогтолцоог байр сууцаа бий тэнд оршин сууж байгаа хүнээ дагасан болгон өөрчлөхөд шинэтгэл чиглэгдэнэ.

Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний үнэ, тариф цаашид өсвөл бага орлоготой айл өрх, тахир дутуу иргэд, өндөр настан зэрэг хүн амын эмзэг хэсэгт төрийн дүгээс нийгмийн хамгаалал үзүүлэх шаардлага зайлшгүй гарна. Энэхүү нийгмийн хамгааллын арга хэмжээг орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний үнэ, тарифын тодорхой хэсэгт улсын дүгээс зөрүүг нөхөн олгох хэлбэрээр хэрэгжүүлнэ.

Удслаас олгох нөхвөрийн хэмжээг өрхийн ам бүлийн тоогоор тооцсон нийгмийн нормт талбайд оногдох орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний хөлс болон өрхийн төлж чадах мөнгөнөөс нормативт хэмжээг үндэслэн тогтооно.

Нөхвөр олгох эх үүсвэр нь нийгмийн халамжийн сан байна.

Орон сууцны нөхлөрийг зарим орны жишгээр орон сууцны нөхлөрийн эрхийн бичиг (ваучер) ашиглан олгох нь зүйтэй гэж үзнэ.

Хүн амын орлого багатай, эмзэг хэсгийн орон сууцны хангамжид төрөөс онцгойлон анхаарт гэлийн хөрөнгөөр тэдэнд зориулсан тусгай сууц (ядуу хүмүүс, өнчин хүүхдийн асрамжийн байр, өндөр настан, тахир дутуу хүмүүст зориулан дотроо ажил, үйлчилгээний байр бүхий орон сууц) барина.

Эдгээр үзэл санааг баримтлан холбогдох байгууллагуудын ажилтнуудаас бүрдсэн ажлын хэсэг орон сууцны нийгмийн хамгааллыг хэрэгжүүлэх журам, зааврыг боловсруулан гаргаж мөрдүүлнэ.

### **Зургаа. Орон сууцны барилгыг барих, санхүүжүүлэх шинэ тогтолцоо бүрдүүлэх талаар**

Орон сууцны барилгыг барих ажилд өрсөлдөөн бий болгох, орон сууцны зах зээлийг бүрдүүлэх, орон сууцны санхүүжилтэд төсвийн бус хөрөнгийг өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлэхэд шинэчлэл чиглэгдэнэ.

Зах зээлийн тогтолцоонд ялангуяа шилжилтийн үед орон сууцныг аль болох зардал багатай барихдаа суугчдын тохитой амьдрах нөхцөл, эрүүл ахуйн шаардлагыг хангахад онцлон анхаарч, амины орон сууцныг түлхүү барина. Үүнтэй уялдуулан орон сууцны эрүүл ахуйн нормуудыг (агаарын эзэлхүүн, температур, урсгалын хурд болон өрөөний дулаан, чийгшилт) тогтоож мөрдөнө.

Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн болон зээлийн хөрөнгөөр ажиллагсдынхаа орон сууцны асуудлыг шийдвэрлэхийг дэмжинэ.

Орон сууцны төлөвлөлтийг боловсронгуй болгож, орон сууцны төрлийг хүн амын бодлого, орхийн бүтэц, орлогын хэмжээнд тохируулж олшруулна. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоог үйлдвэрлэгч хэрэглэгчид шууд үйлчлэхээр өөрчилнө. Орон сууцны банкныг байгуулж, хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөв, орон сууцны хувьчлалын орлого, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өөрийн хөрөнгө, орон сууцны даатгал, донор орнуудаас олгох тусламжийн хөрөнгөөс бүрдүүлж, түүнийг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад орон сууц шинээр барихад зориулж хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл, санхүүжилт олгоход хэрэглэнэ.

## Долоо. Орон сууцны салбарын хууль, тогтоомжийг шинэчлэх талаар

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр орон сууцны салбарт бий болох шинэ харилцааг зохиох хууль, тогтоомжид тусгахад шинэчлэл чиглэгдэнэ. Юуны өмнө иргэний хуулийн орон сууцны хэсэгт зохиох нэмэлт, өөрчлөлт оруулна.

Дараахь хууль, дүрэм, журмыг шинээр боловсруулж гаргана:

- орон сууцны бодлогын тухай хууль;
- орон сууцыг хамтран өмчлөх (хоршоолол), хэсэгчлэн өмчлөх (кондоминум) хэлбэрүүдийн тухай хууль, эрхийн акт;
- орон сууцыг барьцаалах тухай хууль, эрхийн акт;
- орон сууцны ашиглалтын дүрэм;
- орон сууц хувьчлах дүрэм;
- хувьчлах орон сууцыг үнэлэх журам;
- орон сууцны сая байгуулж, зарцуулах журам.

Орон сууцтай холбоотой хууль, дүрэм, журмыг боловсруулахдаа Монгол Улсын бусад хууль, тогтоомжийн актуудад нийцүүлэн боловсруулна.

## Найм. Орон сууцны салбарын хэмжээнд хийх сургалтын талаар

Орон сууцны хувьчлал нь нийт ард иргэдийн эрх ашгийг хондон эмзэг асуудал учраас тус салбарын хэмжээнд харилцагч талуудын тухайлбал, орон сууцны ашиглаат, засвар, үйлчилгээг эрхлэх, барих аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчид, оршин суугч иргэд, өмчлөгчдийн дунд явуулах сургалтыг аль болох өргөн хүрээтэй зохион байгуулна.

Орон сууц хувьчилсны ач холбогдол, зөрөг, сөрөг үр дүгавар, зах зээл дөгжсөн орнуудын туршлага, орон сууцны салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх зайлангүй шаардлага, энэ талаар гарах хууль тогтоомж, дүрэм, журмыг сайтар сурталчлан ойлгуулна.

Нэгэснээр уг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх сэтгэл зүйн бэлтгэл болох төдийгүй, ард иргэдийн хяналт, тусалцааг өргөн ашиглах боломжийг хангана.

Сургалт, сурталчилгааны ажлыг сайн зохион байгуулснаар энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад ямар нэг алдаа, сөрөг үр дүгавар гаргахаас урьдчилан сэргийлнэ.

**Засгийн газрын Өмч  
хувьчлалын комисс**

# МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1994 оны 4 сарын 14 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

## ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 32-Р ЗҮЙЛИЙГ НЭГ МӨР ОЙЛГОН ЗӨВ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

Эд хөрөнгө хураах илэн тухай Монгол Улсын Эрүүгийн хуулийн 32-р зүйлийн заалтыг нэгдмэлээр ойлгон шүүн таслах ажиллагаанд зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Эрүүгийн хуулийн 32-р зүйлийн заалтыг дор дурдсанаар тайлбараасугай:

1. Эрүүгийн хуулийн 32-р зүйлийн «Гэмт үйлдлийн улмаас бий болгосон эд зүйл» гэдэгт гэм буруутай этгээд нь Эрүүгийн хуульд заасан тодорхой гэмт хэрэг үйлдэж хууль бусаар шууд олж авсан иргэний хуульд заасан өмчлөлийн зүйлсийг ойлгоно. Жишээлбэл: хулгайлах, буулах болон дээрэмдэх гэмт хэрэг үйлдэж авсан эд хөрөнгө, мөнгөн тамдэгт, үнэт цаас, шуудангийн марк, зорчигчийн болон ачааны билет зэрэг нь гэмт үйлдлийн улмаас бий болгосон эд зүйлд хамаарна.

2. Мөн зүйлийн «Гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл»-д гэм буруутай этгээд тухайн гэмт хэргийг үйлдэхдээ учруулж болох хор уршиг, явуулыг ихэсгэх, түргэсгэх, хүч нэмэгдүүлэх, хохирогчийн эсэргүүцлийг няцаах, үнэрч болох саадыг зайлуулах, гэмт үйлдлээр олж авсан эд зүйлийн тээж зөөвөрлөх, гэмт хэргийн газраас зугатах зэрэгт хэрэглэсэн төрөл бүрийн гаалт болон хүйтэн зэвсэг, тээврийн төрөл бүрийн хэрэгсэл, хорьтой үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан техник тоног төхөөрөмж, түүхний эд, багаж хэрэгсэл зэрэг хамаарна.

3. Мөн зүйлийн «Гэмт үйлдлийн замаар олсон ашиг, орлого» гэдэгт гэм буруутай этгээд гэмт хэрэг үйлдэж олж авсан эд хөрөнгө, түүний дотор татраг, валютыг аж ахуйн эргэлтэд оруулсны үр дүнд олж авсан эд хөрөнгө, ашиг ор-



лого, түүнчлэн эдгээр эд хөрөнгийг ашиглах явцад бий болсон үр төл, бүтээгдэхүүн, орлогыг хамааруулан ойлгоход зохино. Тухайлбал, хулгайлсан, булаасан, дээрэмдсэн, итгэмжлэгдэн хариусан эд хөрөнгийг авч завшсан, залилан мэхэлсэн гэмт хэрэг үйлдэж хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгийг бусдад хүүтэйгээр зээлүүлэх, илүү өндөр үнээр худалдан борлуулах, үнэ төлбөртэйгээр бусдад ашиглуулах зэргээр ашиг олох, түүнчлэн гэмт үйлдлийн замаар олж авсан эд зүйлийг эзэмших, ашиглах явцад гарсан үр төл, тэдгээрийг ашиглан үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн нь гэмт үйлдлийн замаар олсон ашиг, орлогод хамаарна.

4. Гэмт үйлдлийн улмаас бий болгосон эд зүйл, хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, олсон ашиг орлого, тэдгээрийн үнийг урьдчилсан мөрдөн байцаалтын явцад зохих журмын дагуу нэг бүрчлэн тогтоосон байвал зохино.

5. Гэмт үйлдлийн улмаас бий болгосон эд зүйл, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт үйлдлийн замаар олсон ашиг, орлогыг зөвхөн эд хөрөнгө хураах нэмэгдэл ялын чанартайгаар үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж улсын орлогод шилжүүлж байна.

6. Шүүх эд хөрөнгө хураах ял оногдуулахдаа чухам ямар аргаар олж авсан, ямар нэрийн, ямар хэмжээний үнэтэй эд хөрөнгө, мөнгө хурааж байгаа тухайгаа таслан шийдвэрлэх тогтоолд нэг бүрчлэн зааж байвал зохино.

7. Гэмт үйлдлийн улмаас бий болгосон эд зүйл, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт үйлдлийн замаар олсон ашиг орлого болох нь тогтоогдсон эд хөрөнгө, мөнгийг шаардлагатай тохиолдолд гэм буруутай этгээдийн бусдад учруулсан материаллаг хохирлыг нөхөн төлүүлэхэд хуваарилан олгож болох бөгөөд үлдсэнийг эд хөрөнгө хураах нэмэгдэл ялын чанартайгаар улсын орлогод шилжүүлж байх нь зүйтэй.

8. Тэгэхдээ гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл нь гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь нотлогдсон тохиолдолд түүнийг эд хөрөнгө хураах нэмэгдэл ялын журмаар үнэ төлбөргүй хурааж улсын орлого болгоно. Харин гэм буруутай этгээд нь бусдын өмчлөл, эзэмшил, ашиглаад байсан зэвсэг, хэрэгсэлийг хууль бусаар өөрийн өмчлөлд шилжүүлж гэмт үйлдэлдээ хэрэглэсэн бол тэдгээрийг эд хөрөнгө хураах ялын журмаар хурааж улсын орлого болгохгүйгээр жинхэнэ өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид шилжүүлж байвал зохино.

9. Гэм буруутай этгээдийн гэмт хэрэг үйлдэхдээ хэрэглэсэн зэвсэг хэрэгсэл нь уг хэргийн эд мөрийн баримтаар хураагдан хэрэгт хавсаргадан шүүхэд ирсэн тохнолдолд уг зэвсэг, хэрэгсэлийн онцлогоос хамаарч түүнийг устгах, улсын орлого бэлтгэх алийг шүүх Эрүүгийн байцлан шийтгэх хуульд нийцүүлэн шийдвэрлэж байвал зохино.

10. Эд хөрөнгө хураах ялыг будаан хэрэглэхгүй бөгөөд 1993 оны 8 дугаар сарын 1-нээс хойш гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хамааруулан хэрэглэнэ. Харин 1993 оны 8 дугаар сарын 1-нээс өмнө эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелэгдээгүй байсан бол гэм буруутай этгээдийг уг илаас шүүх чөлөөлнө.

11. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэж байгаа шүүхийн практикийн тухай» Дээд шүүхийн Бүгд хурлын 1982 оны 46-р тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

Ерөнхий шүүгч

Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

## МОНГОЛ УЛСЫН ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН АГУУЛГА, ОНЦЛОГ

### 1. Хууль гарах болсон шалтгаан

Энэ хууль нь Монгол Улсын Валютын зохицуулалтын тухай анхны хууль мөн.

Манай улсад валютын харилцааг зохицуулах хууль социализмын үед ч гэсэн хэрэгтэй байсан. Энэ харилцааг тухайн үед ЭЗЛТЗ-ийн хүрээнд ЭЗХАО банк, ОУХО банк гэсэн хоёр банкны хамтарсан хүчээр шийдвэрлэж, гишүүн орнуудын хоорондын үйлдвэр, худалдааны харилцаанд үүссэн валютын төлбөр тооцооны асуудлыг зохицуулж ирсэн билээ.

Харин зах зээлийн эдийн засагт шилжинэ байгаа өнөө үед дээрх хоёр олон улсын банкны оролцоотойгоор валютын харилцааны асуудлыг шийдвэрлэж явсан зүйл манай улсын эдийн засгийн харилцааны хүрээ улам тэлж, утга агуулга нь өргөжинэ байгаатай холбогдож хамааралгүй болсон. Эдийн засаг, үйлдвэр, худалдааны болон соёл боловсролын харилцаатай бусад орон, илангуяа хоёр том хөрш ОХУ, БНХАУ манай улстай чөлөөт валютаар төлбөр тооцоо хийх боллоо.

Түүнчлэн зах зээлийн үед гадаад худалдаа хүч авч, гадааас бараа оруулах, гадагш нь түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн гаргах үйл явц улам дурдан нэмэгдэх боллоо. Энэ нөхцөлд валютын хэрэгцээ ихсэж, үндэсний валют төгрөг маань чөлөөт валютад хөрвөн гадагш нь гарах, дотоодын зах зээлд бараа элбэгшнэж, үнэ, өртөг, цалин нэмэгдсэнтэй холбогдож үндэсний валют төгрөгийн хомсдол гарах болсон юм. Үүнээс болж Т-М-Т гэсэн сонгомол орчлоос мөнгө сугарч алга болоод харин шууд барааг бараагаар нь солих болсон нь дөвлөх үнийн өсөлт төдийгүй бэлэн мөнгөний хангамж, хүрэлцээтэй шууд холбоотой.

Ийм учраас «Валютын зохицуулалтын тухай» хуулийн нэг зорилт нь Монгол улсын үндэсний валют төгрөгийг үнэгүйдлээс хамгаалах явдал юм.

Зах зээлийн үед илангуяа түүний эхний үе шатанд зарим арга мэтэй өвжин худалдаачид түүхий эд, бараа, материал, бэлэн бүтээгдэхүүнээ гадаадад экспортоор гаргачихаад түүнээс гадаад валютаар буюу чөлөөт валютаар олсон ашиг орлогоо эх орондоо оруулж ирэхгүй, тэндээ, хилийн чанадад эргэлдүүлж улс орны мөнгөний чадавхийг дээшлүүлэх бололцоог алдагдуулж байлаа. Иймд хууль маань аж

ахуйн нэгж, байгууллага, иргэдийн валютын гүйлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулах бас нэгэн зорилтыг агуулаж байна.

Валютын харилцааны талаар төрийн зохих байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж энэхүү харилцаанд оролцогч гадуудын байр суурь, эрх үүргийг зааглаж хуульчлан баталгаажуулах нь зүйтэй байсан юм. Иймд зах зээлийн үед валютын хуулиар зохицуулагдаагүй хүн бүхэн дур дураараа нэг бүрийн валютын гүйлгээ, арилжаа эрхэлдэг болж алт диллерийн хэрэг мэтийн томоохон гэмт хэрэг ч гарлаа. Цаашид ч гэсэн хэрэв хуулиар зохицуулахгүй бол ийм, төстэй гэмт хэрэг гарахгүй гэх газаргүй билээ.

Асуудлын хамгийн гол нь чухамдаа Монгол улсын төлбөрийн хэрэгсэл болсон төгрөгийн ханш унаж, төгрөг хэрэгцээгүй мэт болж эдийн засгийн аюултай үр дагавар гарч болзошгүй байна. Үнэнийг хэлэхэд Улаанбаатар хотын гудамж бүрт, тэр ч байтугай аймаг, сумдын төвд хүртэл валютаар худалдаа хийх дэлгүүр, мухлаг гарах болсон явдал үндэсний валют төгрөгийн байр суурийг ганхуулах, алдагдуулах нөхцөл байдлыг бүрдүүлж байна. Хууль гарах шалтгаан нь ийм л үндэстэй юмаа,

## 2. Хуулиар юуг зохицуулав.

Үүнтэй холбогдуулж хэлэхэд «Валют» гэсэн нийтлэг ойлголтод үндэсний валют, гадаад валют, тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлсийг хамааруулан оруулж хуульчлан тодорхойлж өглөө.

Эдгээрийн дотроос «Үндэсний валют» гэж эргэлтэд байгаа монгол улсын мөнгөн тэмдэгт-төгрөгийг, гадаад валют гэж эргэлтэд байгаа гадаад улсын мөнгөн тэмдэгтийг тодорхойлж түүгээмэл хэрэглэгддэг үнэт цаас төлбөрийн хэрэгсэлийг эдгээр валюттай адилтган авч үзлээ. Цаашидбал «Валютын үнэт зүйлс» гэдэгт юу багтах вэ гэдгийг «Мөнгөжсөн алт», «цэвэршүүлсэн алт», түүнтэй адилтгах үнэт металл, эрдэнийн чулуутгийн хүрээнд авч үзээд товч тодорхойлолтыг нь тогтоосон болно.

Валютын зохицуулалтын асуудал дээр урьд өмнө нь зааг тогтоогдож хуульчлан мөрдөж байгаагүй бүрхэгдүү явж ирсэн зарим зарчмын зүйлүүдийг зааглаж өглөө. Тухайлбал валют, валютын үнэт зүйлсийг захиран зарцуулахад Улсын Их Хурал, Засгийн газар, Монголбанк имар эрх үүрэгтэй вэ

гэдгийг хуулиар батлав. Үүнийг дагалдаж арилжааны банкууд, аж ахуйн нэгжүүд, байгууллага, иргэд ямар эрх үүрэгтэй байх вэ гэдгийг тогтоох нь зөв зүйтэй хэрэгжүүлэх, гүйцэтгэн зарцуулахад зарчмын ач холбогдолтой байлаа.

Валютын зохицуулалтын тухай Монгол улсын хуулиар бол Улсын Их Хурал энэ тухай төрийн бодлогыг тодорхойлох, гадаадын зээл, гадаад тэнцэлийн төслийг хянан шийдвэрлэх, валютын нөөцийн доод хэмжээг тогтоох, цэвэршүүлсэн алт болон бусад бодлогын асуудлын зарчмын зүйлүүд дээр бүрэн эрхтэй байна. Засгийн газар нь гадаад валютын эх үүсвэр нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцэл чадварыг сайжруулах, хяналт тавих, гадаадын зээл авах, хэрэгжүүлэх зэрэг бүрэн эрхтэй байдаг бол, Монголбанк нь дотоод, гадаадын зах зээл дээр, валютын гүйлгээг зохицуулах, хэрэгжүүлэх, эрхлэх, нөөцийг нэмэгдүүлэх, үр ашигтай байршуулах зэрэг зарчмын бүрэн эрхийг эдлэх юм.

Энэ хуулиар, түүнчлэн, Монгол улсад байнга, түр оршин суудаг хүмүүсийн валют эзэмших, захиран зарцуулах эрх үүргийг тодорхойлон тогтоож өгсөн.

### 3. Хуулийн ач холбогдол

Монгол улс чөлөөт эдийн засгийн системд шилжиж байгаа учраас энэ хуулиар валютын асуудлыг уян хатан болгож нэг үгээр хэлбэл цэвэр либералчилж өглөө. Уг хуулийн практик гол санаа нь чөлөөт валютын хувьд зах зээлийг бараг Гонконг, Сингапур маягийн нээлттэй байлгахыг чухалчилсан, түүнд чиглэсэн юм. Гадаадын валютыг чөлөөтэй оруулах, хуулийн хүрээнд чөлөөтэй гаргах нөхцөл бололцоог хуулиар баталгаажуулсан. Ялангуяа Монголын иргэд ганзагын наймаа эрхэлж байгаа энэ үед тодорхой хэмжээний валютыг гадаадад гаргаж, оруулах эрхийг нь хангаж, хуулиар баталгаажуулсны үндсэн дээр тэдгээр нь ямар нэгэн замаар хохиролд учрахдаас хамгаалж байгаа юм.

Иргэдийн баталгаатай үйл ажиллагааг хангахын хувьд онцгойлон тэмдэглэх нөгөө нэг асуудал бод хуучин хуулийн заалтаар Монгол улсын иргэд хоорондоо валют худалдан авах, худалдахыг хориглож, хууль бус гэж үзэж харвиулага хүдээлгэдэг байсан юм. Энэ хууль гарснаар манай иргэд барааны зах дээр үү, нарны титэмд үү, арилжээны банкнд уу валют худалдан авах эрхтэй болно.

#### 4. Хуулийн хяналт

Аливаа хууль нь өөрийн хяналтын системтэй байх нь зүйн хэрэг. Хяналтын системгүй хууль байж болохгүй нь мэдээж. Тийм учраас энэ хуулинд хяналт тавих үүргийг Монгол банкнд өгсөн. Хуучин валютын хяналтыг Сангийн чам, Засгийн газар, Улсын банк зэрэг байгууллагууд хийж байсан бол одоо валютын захиран зориулах эрх үүргийн биелэлтэд хяналт тавих эрх үүргийг төвлөрүүлж Монголбанкнд харууцуудаг болж байгаа юм. Үүнийг Монголбанк бие даасан байдалтай хяналтын систем бүхий байхаар зохион байгуулж аливаа зөрчил, дутагдал илрүүлбэл түүнийг дахин давтахгүй байхын тулд зохих харууцлага хүдээлгэж байхаар хуулинд тусгасан болно. Эдгээр хүдээлгэх харууцлага нь гаргасан зөрчил, хийсэн үйлдлийн шинж тэмдэг, агуулгыг харгалзан орлогыг хураах, хохиролгүй болгох, төртөх зэрэг шийтгэл байхаар хуулиар тогтоогдсон.

Тухайлбал, Монголбанк өөрийн бүрэн эрхийнхээ дагуу Улсын Ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын байцаагчдаараа дамжуулан Монгол Улс дахь аж ахуйн нэгж, байгууллагын валютын гүйлгээнд хяналт тавина. Энэхүү хяналт нь өмчийн төрөл, хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр валютын гүйлгээтэй холбоотой баримт, сэлт, бүртгэл, тайлан, мэдээ төрөл бүрийн эрхийн актуудын биелэлт, хэрэгжилтийн байдалд чиглэнэ. Энэ хяналтын хурц үзүүр нь юуны өмнө валютын арилжаа, гүйлгээ болон Монгол улсад валют оруулах, гаргах зэрэгтэй холбогдож үйлдсэн зөрчлүүдийг илрүүлэхэд чиглэх нь мэдээж. Үүний тулд холбогдох асуудлаар байгууллага, албан тушаалтан иргэдээс мэдээ, гоморхойлолт, тайлбар, шаардлагатай баримт гаргуулан авах, үр дүнгээр нь акт тогтоох, гүйцэтгэх, хугацаатай үүрэг өгөх, биелэлгүй бол захиргааны харууцлага хүдээлгэх, гадаад төлбөр тооцоо хийх зөвшөөрлийг цуцлах, хэрэв гэмт хэргийн шинж чанартай бол мөрдөж байцаахад нилжүүлэх хүртэл арга хэмжээ авч байх юмаа.

Жиншээлбэл, иргэд, гадаад валютын орлогсо арилжааны банкиндаа 60 хоногийн дотор оруулаагүй бол, гадаадад хөрөнгө байршуулахдаа Сангийн даманд бүртгүүлээгүй бол 5000—25000 төгрөгөөр, арилжааны банк харилцагчийнхал нууцыг хадгалж чадаагүй, гүйлгээ хийхгүй, хүү төлөөгүй бол 20000—25000 төгрөгөөр тус тус төргөж байхаар хуулинд тусгасан байна.

Мөн түүнчлэн арилжааны банк нь төгрөгийн ханшид нөлөөлөхүйц томоохон гүйцгээг Монгол банкны зөвшөөрөлгүй хийсэн бол, иргэд валютын үйл ажиллагааг зөвхөн монгол-банк, арилжааны банкаараа дамжуулан гүйцэтгээгүй бол, зөвшөөрөлгүй, зөвшөөрсөн хэмжээ хэтрүүлж валютын үйл ажиллагаа эрхэлсэн бол иргэд болон арилжааны банкыг 15—25000 төгрөгөөр торгож байх зэргээр хариуцлага хүлээлгэхээр тусгасан явдал энэхүү хууль нь иргэд, банкны валютын арилжаа наймаа, бусад үйлдэлд эрх тэгш, ижил төстэй шуларга хандлагатай гарсныг харуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Д. Данзан

## ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ

«Монгол Улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт, Бүгд Найрамдах Улс мөн» гэж манай шинэ Үндсэн хуулинд зарлан тунхагласан билээ. Дэлхийн аль ч улс орны хувьд тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын нэгэн баталгаа нь төрийн бэлгэ тэмдэг байдаг юм. Бид Үндсэн хуульдаа «төрийн сүлд, туг, далбаа, тамга, дууллыг төрийн бэлгэ тэмдэг» хэмээн тодорхойлоод төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар бататгахаар заасны дагуу Улсын Их Хурлын 1994 оны хаврын чуулганаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн энэхүү хуулийн төслийг хэлэлцэн саяхан батлав.

Монгол Улс төрийн бэлгэ тэмдгээ эрт дээр үеэс дээдлэн хүндэтгэж ирсэн уламжлалтай орон. Төв Азийн нүүдэлчин олон аймгууд дотроос монголын язгуурын аймгуудын нэг болох Нирун аймаг нь «Шонхор» шувууг сүлдээ болгон дүрслээд, шүтэн биширч, ямар ч дайн байладаанд дайсны гарт оруулахгүй нандигнан хадгалж явсан тухай домог бий. Түүнчлэн эдгээр нүүдэлчин аймгууд Чингис хааны үед бэлгэ тэмдгээ дээдлэн төрт ёсны хүндэтгэлийн нэгэн чухал бэлгэдэл болгон ашиглаж ирснийг нэгтгэх баримт «Монголын нууц товчоо» хэмээх алтан сударт нэг бус удаа гардгийг хэлэхэд илүүдэхгүй буй заа. Уг бүтээлд «Тэгээд эсгий туургатай улс энх шударга болж, барс жил (1206) Онон мөрний эхэнд есөн хөлт цагаан тугаа мандуулаад Тэмүжинд Чингис хаан (Далай хаан) цолыг өргөн» гэсэн байдаг билээ. (Монголын нууц товчоо, Улаанбаатар, 1975 он, 164 дэх тал).

Манай ард түмэн Бүгд Найрамдах Улсаа байгуулан тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа даяар олонд зарлан тунхагласан 1924 оноос төрийн бэлгэ тэмдгээ хуульчлан баталгаажуулж эхэлсэн түүхтэй.

БНМАУ-ын Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1940 оны 60 тоот тогтоолоор «Сүлд тэмдгийг зөвхөн улсын ба жишээнд засаг захиргааны газрууд өөрийн байгууллагын туг, тамга, адресад хэрэглэх ба бусад ямар нэгэн газар дур зоргоор үүд хаалганы адресад хэрэглэж үл болно» хэмээн төрийн сүлдийг дээдлэн хэрэглэх журмыг тогтоох анхны эрх зүйн шийдвэр гаргаж байжээ. Үүний дараагаар 1945 онд Засгийн газрын тогтоолоор Японы милитаристуудыг ялсны ойг тохиолдуулан 1945 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийг амралтын өдөр болгохдоо «энэ өдөр Улсын олон байгууллагууд нь өөр



төрийн албан конторын байшин байрууд дээр «БНМАУ-ын далбааг хийгээсүгэй» хэмээн зааж байжээ.

1952 оны 6 дугаар сарын 6-нд Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн 46 тоот зарлиг гарч «төрийн далбааг мандуулах журмыг баталж өдрүүдийг товлон тогтоожээ. Тухайлбал, Ардын хувьсгалын өдөр, БНМАУ-ыг тунхагласан өдөр, Үндсэн хуулийн өдөр, Монгол Ардын хувьсгалт цэрэг байгуулагдсан өдөр, Дэлхийн хөдөлмөрчдийн баяр ба Октябрийн социалист Хувьсгалын зэрэг өдрүүдэд БНМАУ-ын яамд, Сайд нарын Зөвлөлд харьяалагдах албан газрууд ба гадаадад суугаа дипломат төлөөлөгчдийн газрууд болон аймаг, хотын бага хурлын Тэргүүлэгчдийн газруудын байранд төрийн далбааг занал мандуулж байх журмыг тогтоосон бөгөөд 1956 онд Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн 80 тоот зарлигаар төрийн далбааг тогтмол мандуулах өдрүүдийг өөрчлөн тоог нь нэгдээдээр цөөрүүлсэн байна. Үүний хамт төрийн далбааг Засгийн газрын ордон дээр тогтмол мандуулж байхаар энэ зарлигаар шинэчилж, баяр ёслолын өдрүүдэд төрийн далбаагаа барих нь хөдөлмөрчдийн сайн дурын хэрэг хэмээн тогтоожээ.

Ардын Их Хурлын Тэргүүлэгчид 1959 оны 154 дүгээр тоот зарлигаараа Хөдөлмөрчдийн Депутатын бүх шатны хурлын сонгуулийн санал хураалтын өдөр, мөн ХДХ-ын чуулган хуралдаж байсан үед төрийн далбааг мандуулж байхаар тогтсон байна.

1970 онд батлагдсан аймаг, хотын Хурлын дүрэм, 1978 онд батлагдсан Консулын дүрмүүдэд төрийн далбааг байнга мандуулах эрхийг эдгээр газруудад олгожээ.

Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1980 оны 113 тоот зарлигаар төрийн далбааг бөхийлгөх буюу хагас буулгах журмыг тогтоосон байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 107 тоот зарлигаар «Төрийн бэлгэ тэмдгийн тухай дүрэм»-ийг баталж энэ талаар урьд өмнө мөрдөгдөж ирсэн бүх зарлиг, шийдвэрүүдийг хүчингүй болгосноор Монгол Улс төрийн бэлгэ тэмдэг дээдлэн хэрэглэх эрх зүйн нэгдмэл шийдвэртэй болсон юм.

### **Төрийн сүлд:**

Монгол Улсын 1924 онд баталсан анхдугаар Үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлд: «... соёмбо үсэг, түүний доод этгээдэд бадамлинхуа цэцгийн зураг бүхий сүлд тэмдэг хэ-

рэглэн ивуулбал зохино» хэмээн тодорхойлжээ. Ийнхүү Алтайн соёмбо үсэг нь тусгаар тогтносон Бүгд Найрамдах Монгол Улсын анхны сүлд болсон түүхтэй. Монгол Улс Үндсэн хуулиа 1940, 1960 онд өөрчлөх бүрт төрийн сүлдээ өөрчлөн шинэчилж байсан юм.

1940 оны Үндсэн хуулийн арван нэгдүгээр бүлгийн ерэн хоёрдугаар зүйлд: «БНМАУ-ын сүлд тэмдэг бол дугуй хэлбэртэй, дунд нь Монгол Улсын хангай, тал, говь нутаг дээр нарни зүт уурга бариад давхиж яваа морьтой ард байх ба дугуйн хөвөөгөөр өвс ногооны дээр хонь, үхэр, тэмээ, ямааны толгойг хоёр талд зурж, дугуйн дээд талыг дан алхан хэргээр хүрээлэн дунд нь таван хошуу тэмдэг байна» гээд өвс ногооны доод уулзварт улаан лент дээр «Бүгд Найрамдах Монгол Ард Улс» гэсэн бичиг байхаар баталжээ. 1960 оны Үндсэн хуулийн есдүгээр бүлгийн ердүгээр зүйлд: «БНМАУ-ын сүлд бол тарианы түрүүгээр хөвөөлсөн дугуй хэлбэртэй байна. Тарианы ишнийг хурд араагаар холбож, эдгээрийг «БНМАУ» гэсэн үсэг бүхий улаан, цэнхэр өнгийн туузаар ороож зангидсан байна. Сүлдийн төвд БНМАУ-ын хангай, говь, тал хосолсон нутгаар мандах коммунизмын наран өөд хурдалж яваа морь унасан хөдөлмөрчин хүн зурсан байна. Сүлдийн магнайд тариан түрүүний хоёр үзүүрийн хооронд дундаа алтан соёмбо үсэг бүхий таван хошуу байна» хэмээн тодорхойлсон байдаг. Монгол Улсын одоогийн сүлд бол манай дөрөвдэх сүлд бөгөөд шинэ Үндсэн хуулийн 12 дугаар зүйлд элснээр: «Арван цагаан өнгийн бадам цэцэг суурьтай, төгсгөлгүй үргэлжлэн дэлгэрэх түмэннасан хэргээр хөвөөлсөн, мөнх тэнгэрийг бэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй байна. Сүлдийн төв хэсэгт Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэг хиймөрийг илтгэсэн алтан соёмбо, эрдэнийн хүлгийг хослуулан дүрсэлсэн байна. Сүлдийн хүрээний магнайн хэсэгт эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийг бэлгэдсэн хүслийг хангагч чандмань эрдэнэ, доод хэсэгт эх газрыг төлөөлсөн ногоон өнгийн уулан хээ, ашиа тэвжихийн өлзий хутаг орисон хүрдийг тус тус дүрсэлнэ. Хүрдийг хадгаар дээдэн сүлжсэн байна» гэж тодорхойлсон юм.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд төрийн сүлдийг өнгө алган дүрсэлэхдээ хэрэглэх өнгө бүрийн хослолыг нарийвчлан тогтоож, түүнийг байрлуулах газруудыг тодруулан зааж өгнэ. Шинэ хуулиар төрийн сүлдийг байрлуулах газруудын

хувьд нэлээд өөрчлөлт орсны зарим нь нутгийн удирдлагын бүтэц, дохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой юм. Түүнчлэн хуучин дүрмэнд Улсын банкны мөнгөн тэмдэгт, доос, улсын зээллэгийн облигаци, иргэний паспорт, түүнчлэн иргэдэд олгодог дипломат бодон бусад гадаад паспортад дүрсэлж байсныг одоогийн хуулиар шаардлагагүй гэж үзээд өмнө нь төрийн сүлд байрлуулж байсан газрууд дээр нэмж талд тэрэгний зүтгүүр, суудлын вагоны хажуу талд төрийн сүлдийг байрлуулахаар шинээр нэмж тусган.

### **Төрийн туг:**

Монгол Улсын шинэ Үндсэн хуульд төрийн тугийг төрийн бэлгэ тэмдгийн нэг хэмээн үзэж, «Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн» хэмээн тодорхойлсон юм.

Монгол Улсын Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд төрийн Их цагаан тугийг сөөн хөлт туг байна хэмээн тогтоож, тэдгээрийн нарийвчилсан хэмжээсүүдийг хуульчлан баталлаа. Төрийн тугийг цагаан зүсмийн адууны дэл сүүлээр ганц хувь үйлдэж, төрийн ордонд байрлуулахаар заав, Түүнийг кино, уран сайхны арга хэмжээнд зөвхөн Засгийн газрын зөвшөөрлөөр үйлдэж ашиглахаас бусад аливаа тохмолдолд дурмаалган хийж үйлдэхийг хуулиар хориглов.

Жил бүр Монгол Ардын Хувьсгалын ойн байрын өдрүүдэд баяр наадмын ивч талбайд төрийн тугийг хүндэтгэн залж байхаар заагаад уг журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч баталж байхаар боллоо.

### **Төрийн далбаа:**

Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийн дотын есдүгээр зүйлд төрийн далбааны тодорхойлолтыг «Улсын гүт далбаа улаан өнгөтэй бөгөөд дунд нь улсын сүлд тэмдгийг оруулан үйлдүүлж гүйцэтгүүлбэл зохиомой» хэмээн тодорхойлжээ.

1940 оны Үндсэн хуульд төрийн далбааны тодорхойлолтыг нэлээд өөрчилж: «БНМАУ-ын туг нь 1:2-ын хэмжээний улаан өнгийн эдээр үйлдэгдэх бөгөөд уул тугийн төнд Улсын сүлд тэмдэг байх ба түүний хоёр талаар БНМАУ гэсэн үсэгтэй байна» гэж баталсан ажээ.

1960 оны Үндсэн хуульд БНМАУ-ын төрийн далбааг улсын сүлдийг үндэслэн хийнэ, БНМАУ-ын төрийн далбааг улаан, цэнхэр өнгийн эдээр үйлдэх бөгөөд тэгэхдээ гурав ху-

ваасны нэгний хэмжээтэй дунд тал нь цэнхэр огторгуйн өнгөтэй байх ба түүний хоёр хажуу нь улаан өнгөтэй байна. Шинд ух талын улаан дэвсгэрийн дээд хэсэгт алтан таван хошуу түүний дор мөн алтан соёмбо үсэг байна. Даалбааны өргөн урт хоёр 1:2-ын харьцаатай байгаа гэж тодорхойлсныг үндсэндээ өнөөг хүртэл хэрэглэж ирсэн бөгөөд 1992 оны Үндсэн хуулиар алтан таван хошуугүйгээр зөвхөн алтан соёмбо байрлуулахаар тогтоожээ.

Шинэ хуульд төрийн далбааг дээдэн хэрэглэхдээ хуучин дүрмээр зөвхөн мандуулах хэлбэрээр ашиглаж байсныг өөрчилж мандуулах, байрлуулах, дүрслэх гэсэн гурван хэлбэрээр нарийвчлан зааж өгөн, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай болон Хилийн хуулийн дагуу төрийн далбааг орон нутагт мандуулах, байрлуулах тохнолдлуудын хувьд зарим өөрчлөлт орж төрийн далбааг мандуулах тохнолдлыг байнга ба түр гэж илган тодрууллаа.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай дүрэмд орон даяар гашуудал зарласан өдөр, түүнчлэн гашуудал зарлаагүйгээр төрийн эмгэнэл илэрхийлэх үед бөхийлгөхөөр заасан байсныг өөрчилж одоогийн хуулинд зөвхөн орон даяар гашуудал зарласан тохнололд байнга буюу түр мандуулж байгаа төрийн далбааны аль алиныг бөхийлгөхөөр тогтлоо.

Хуучин дүрмээр төрийн далбааг улсын бүртгэлд бүртгэгдсэн иргэний агаарын хөлөгт дүрслэж байхаар заасныг өргөтгөж улсын бүртгэлтэй иргэний агаарын хөлөг, усан тээврийн хэрэгсэл дээр өнгө илган дүрслэж байхаар болов.

### **Төрийн тамга:**

Тамга бол хэлээнээс монгол төрийн баталгаа, үйл ажиллагааны нэг гол шинж тэмдэг болж ирсэн уламжлалтай. Манжийн ноёрхолд байх үеийн монголын зургаан аймгуудын тамга нь суумал арслангийн дүрс бүхий барилтай дөрвөлжин хэлбэртэй байсан бөгөөд тэдгээрийн зарим нь улсын түүх, соёлын өв болон эдүгээг хүртэл хадгалагдан үлджээ.

1924 оны анхдугаар Үндсэн хуульд тамгийн талаар тодорхой зүйл бичигдсэн байдаг. Эд хуулийн дөрчин долдугаар дүгдэг: «Улсын Их Хурлаас дараалан, Засгийн газар, олон явдлын нам, албаны газруудын тамгыг нэм дөрвөлжин бөгөөд нүүрийн дундад соёмбо гэдэг эрхэм үсэг, түүний хоёр этгээдэд уул газрын нэр сэлтийг үйлдүүдэн гүйцэтгүүлбэл зохино» гэж заасан нь төрийн тамгаа хуулиар баталгаажуул-

сан аяхины эрх зүйн үндэс байв. Харин 1940, 1960 оны үндсэн хуулиудад тамгыг төрийн бэлгэ тэмдгийн бүрэлдэхүүнд оруулалгүй явж ирснийг 1992 оны Үндсэн хуулиар өөрчилж төрийн бэлгэ тэмдэг болгон баталсан юм. Шинэ Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 6 дэхь хэсэгт «төрийн тамга дөрвөлжин хэлбэртэй, голдоо төрийн сүлдтэй, сүлдний хоёр талаар Монгол Улс гэсэн бичээстэй, арслангийн дүрс бүхий баруультай байна» гэж тодорхойлоод төрийн тамгыг Монгол Улсын Ерөнхийлөгч барьж байхаар тогтоосон юм.

Төрийн тамгыг нэгэнт Монгол Улсын Ерөнхийлөгч барьж байх учир сонгуулиар Ерөнхийлөгч солигдоход төрийн тамгыг хуучин Ерөнхийлөгчөөс шинэ Ерөнхийлөгчид зааж гардуулах журмыг Улсын Их Хурал баталж байхаар Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд заав. Монгол Улсын Их Хурал 1994 онд явагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа шинээр сонгогдсон Ерөнхийлөгчийн тагараг өргөх журмыг батлахдаа төрийн тамга залах журмыг хамтад нь баталсан учир энэ талаар дахин шинэ журам гарган батлах шаардлага энэ удаад байсангүй.

Төрийн тамгыг нул мөнгөөр, гар аргаар ганц хувь үйлдэх ба түүнийг тодорхой дүрс хэмжээнийг одоогийн хуулиар тодорхойлдоо. Төрийн тамгыг Монгол Улсын Үндсэн хуулийн уг эхийн хуудас бүр дээр Монгол Улсын хууль, мөн Улсын Их Хурлаар соёрхон баталсан олон улсын гэрээ зэргийн уг эхийн эхний хуудас дээр дарж байхаар тогтодоо. Төрийн тамгыг залгаах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч баталж байх нь зүйтэй гэж Улсын Их Хурал үзэв.

### Төрийн дуулал:

Монгол Улс дэх 1950 оны 4 дүгээр сарын 26-нд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 43 тоот зарлигаар эрдэмтэн зохиолч Ц. Дамдинсүрэнгийн зохиосон уг, хөгжмийн зохиолч Л. Мөрдөрж, Б. Дамдинсүрэн нар ая оруулсан «БНМАУ-ын Сүлд дуулал»-ыг төрийн дуулал болгон баталж 1950 оны 5 дугаар сарын 1-нээс эхлэн улс даяар дуулж эгшиглүүж байхаар тогтоосон юм.

1951 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 130 тоот зарлиг гэрч төрийн дууллын үгийг өөрчилж зохиолч яруу найрагч Ц. Гайтаа, Ч. Чимид нарын зохиосон төрийн дууллын үгийг дагуу шинэчилж дууллын аяыг хэвээр хэрэглэхээр баталсныг 1990 он хүртэл мөрдөж ирсэн боловч 1990 оноос Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар төрийн дуул-

лын үгийг 1950 онд эрдэмтэн зохиолч Ц. Дамдинсүрэнгийн зохиосон үгийн нэг, гурав дахь бадгийг дахилтын хамт хэрэглэж байхаар тогтоосон юм.

Ингээд Улсын Их Хурлын энэ хаврын чуулган Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийг батлахдаа эрдэмтэн, зохиолч Ц. Дамдинсүрэнгийн үгийг нь зохиож, хөгжмийн зохиолч Л. Мөрдорж, Б. Дамдинсүрэн нарын ая оруулсан 1950 оны төрийн сүлд дууллын нэг, гуравдугаар бадгийг төрийн дуулал болгон дээдэн хэрэглэж байхаар баталлаа.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд төрийн дууллыг эгшиглүүлэх тохиолдлыг нэлээд тодорхой оруулсан бөгөөд бүх ард түмний баяр ёслолд зориулсан баярын хурал, цуглаан, ёслолын ажлалатаа, эх орны өмнө гарамгай гавьяа байгуулсан хүмүүсийн дурсгалд зориулсан хөшөө, цогцолборыг нээх, радио өргөн нэвтрүүлгийн үндсэн хөтөлбөр эхлэх ба төгсөх, ард түмний баяр ёслолд зориулсан телевизийн хөтөлбөрийн эхэнд төрийн дуулалаа эгшиглүүлдэг байсан хуучин уламжлалаа хэвээр хадгалсны дээр төрийн тугийг хүндэтгэн заах, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүдийг тэнгэрэг өргөх ёслолын дараа төрийн дуулалаа эгшиглүүлдэг байхаар нэмж тусгалаа.

Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нь төрийн бэлгэ тэмдгээ гүнээ дээдэн хүндэтгэж бүх ард түмний баяр наадам, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээний үед төрийн сүлд, далбаагаа барих, төрийн дууллыг эгшиглүүлэх эрх чөлөөтэй байхаар энэ хуулинд тусгагдлаа. Хуулийн биедэлтэд бүх шатны Засаг дарга нар хяналт тавих бөгөөд төрийн бэлгэ тэмдгийг гутган доромжилсон тохиолдолд мөнгөн торгууль оногдуулах эсхүл 14—30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэлийг шүүгч, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн байгууллагын ажилтан, хилийн төлөөлөгчийн зүгээс ногдуулж байхаар болов.

Монгол Улсын Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль шинээр батлагдсантай холбогдон улсын хилийн багана дахь төрийн сүлдийг шинэчлэх ажлыг 1994 онд багтаан дуусгах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд Төрийн бэлгэ тэмдгийн хуультай холбогдсон өмнөх шийдвэрүүдээ шинэ хуульд нийцүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт үүрэг болгов.

---

**СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:**

Ерөнхий зөвлөхч **Н. Ринчиндорж**  
Нэрийн бичгийн дарга Сан, Жаргалахайхан  
Ганжууд **Т. Балсансүрэн**  
**Ч. Баян**

Техник редактор **Т. Сарантуяа**  
Уршилж хийсний Сан, Жаргалахайхан  
**Б. Янжинпалам**

Үйлдвэрт шилжүүлсэн 1994 оны 5-р сарын  
10-нд, Өрхлөгчид 1994 оны 6-р сарын 10-нд, Хял-  
лаатанд 1994 оны 6-р сарын 30-нд, Хяназлийн  
хуудас 5,5, Хявалсан тоо 4370 шилжсэн.

**Застгийн газрын хэвлэх үйлдвэр**